

2026

ХАВРЫН ЧУУЛГАН

ДОРЖСҮРЭН

ҮҮРИЙНТУЯА

Монгол Улсын Их Хурлын гишүүн

Монгол Улсын Их Хурал



ДОРЖСҮРЭН
ҮҮРИЙНТУЯА

Монгол Улсын Их Хурлын гишүүн

Харьяалагдаж буй байнгын хороо

- Эдийн засгийн байнгын хороо
- Төсвийн байнгын хороо

Улсын Их Хурал дахь Монгол-Шведийн парламентын бүлгийн дарга

Улсын Их Хурал дахь Монгол-Арабын Нэгдсэн Эмиратын парламентын бүлгийн дарга

Монгол Ардын Намын Удирдах зөвлөлийн гишүүн

МАН-ын дэргэдэх Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Ерөнхийлөгч

uuriin-tuya.mn

Доржсүрэн Үүрийнтуяа

uuriintuya@parliament.mn

2026
ХАВРЫН ЧУУЛГАН

УЛСЫН ИХ ХУРАЛ

- Санаачилсан хууль
- Хамтран санаачилсан хууль
- Зарчмын зөрүүтэй санал
- Ажлын хэсэг
- Асуулга - Асуулт
- Парламентын бүлэг
- Онцлох байр суурь

ТОЙРОГ

- Бодлогын ажил
- Хөрөнгө оруулалт
- Иргэдийн санал хүсэлт, уулзалт
- Шагнал урамшуулал
- Уулзалт, хэлэлцүүлэг
- Хандив, тусламж

УЛС ТӨР

- Монгол ардын нам
- Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо
- Гадаад харилцаа

ӨМНӨХ ҮГ



УИХ-ын гишүүний үйл ажиллагааны үндсэн зорилт нь хууль тогтоох үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын зэрэгцээ улс орны хөгжлийн бодлого, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, мөн тойргийнхоо иргэдийн санал хүсэлтийг төрийн бодлого, үйлчилгээтэй уялдуулан бодит шийдэлд хүргэхэд оршдог.

Миний бие иргэдийн амьдралд тулгамдаж буй асуудлыг бодит баримтад тулгуурлан тодорхойлж, тэдгээрийг төрийн байгууллагуудын шийдвэр гаргах түвшинд хүргэх, орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр онцгойлон анхааран ажиллалаа.

Энэ удаагийн хаврын ээлжит чуулганаар бизнесийн орчныг сайжруулах, төрийн өмчит компанийн засаглалыг шинэчлэх, уул уурхайн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, баялгийн үр өгөөжийг шударга, хүртээмжтэй хуваарилах, бүсчилсэн хөгжлийг эрчимжүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүн ам зүй, хүүхэд, гэр бүлийн бодлогыг боловсронгуй болгоход чиглэсэн олон чухал хууль, тогтоомжийг хэлэлцэн баталлаа.

Эдийн засгийн байнгын хорооны гишүүний хувьд төрийн өмчит компанийн засаглалын шинэчлэл, уул уурхайн эрх зүйн шинэчлэлийн асуудлаар бодлогын санал боловсруулж, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцлоо. Түүнчлэн “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийг санаачлан батлуулж, “Санхүүгийн хоршооны тухай” хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Мөн тойрогт тулгамдаж буй боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, нийгмийн хамгааллын салбарын асуудлыг шат дараатайгаар хөндөн, шийдвэрлүүлэх чиглэлээр холбогдох яам, агентлаг, Засгийн газар, Улсын Их Хурлын холбогдох бүтцийн байгууллагуудтай хамтран ажиллахын зэрэгцээ иргэдээс ирүүлсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүдийн оролцоог өргөжүүлэхтэй холбоотой санал, хүсэлтийг бодлого, хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд тусгах чиглэлээр ажиллалаа.

Энэхүү тайланд 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хэрэгжүүлсэн хууль тогтоох болон парламентын хяналтын үйл ажиллагаа, тойрогт хэрэгжүүлсэн ажил, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэсэн байдал, цаашдын зорилт, бодлогын чиглэлийг нэгтгэн танилцуулж байна.

АГУУЛГА:

УИХ-ЫН ХАВРЫН ЧУУЛГАНЫ ОНЦЛОГ 6

ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ, ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИН АЖИЛЛАВ.

САНААЧЛАН БАТЛУУЛСАН ХУУЛЬ 9



ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ЭХЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛЖ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛДЭГ УРАМШУУЛАЛ, ДЭМЖЛЭГИЙН ТОГТОЛЦООНД БҮРЭН ХАМРУУЛНА

УИХ-Д ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ 12



САНХҮҮГИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛНЭ

ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛ 17

ХҮҮХДИЙГ АМЬД ДОНОР БОЛГОХГҮЙ БАЙХ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООГ ХУУЛЬЧЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БИЙ БОЛГОВ

ХАМТРАН САНААЧЛАН БАТЛУУЛСАН ХУУЛЬ 10




МОНГОЛ УЛСЫН ТУЛГУУР САЛБАР БОЛОХ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН СУУРЬ ХУУЛЬ БАТЛАГДЛАА



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ХУУЛЬ БАТЛАГДЛАА

ЯРИЛЦЛАГА 13



АЖЛЫН ХЭСГИЙГ АХАЛЖ БАТЛУУЛСАН ХУУЛЬ 18



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ АХЛАН АЖИЛЛАЛАА

ПАРЛАМЕНТЫН БҮЛЭГ 19




МОНГОЛ-ПОЛЬШИЙН ПАРЛАМЕНТЫН БҮЛГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

ЛОББИ БҮЛЭГ 22



ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ПАРЛАМЕНТЫН БҮЛГИЙГ БАЙГУУЛАХ САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭВ

ЯРИЛЦЛАГА 26



ТОЙРОГ 34

- “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН ААНОАТ-ЫН НЭГ ХУВИЙН ХӨНГӨЛӨЛТ БОДИТ ҮР ДҮНГЭЭ ӨГЧ ЭХЭЛЛЭЭ
- САНХҮҮЖИЛТ НЬ УДААШИРСАН, ГАЦСАН СУРГУУЛИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ СЭРГЭЭЖ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭВ
- ХОЙД БҮСИЙН ХАВДРЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОДЛОГЫН САНААЧИЛГА ХЭРЭГЖИЖ БАЙНА
- АЛСЛАГДСАН СУМ БАГТ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХҮРТЭЭМЖ НЭМЭГДЭНЭ.
- ИРГЭДИЙН САНАЛ ХҮСЭЛТ

ОЛОН УЛСЫН ХУРАЛ, УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ 48

ОНЦЛОХ АЛБАН УУЛЗАЛТ 50

СОЦИАЛ ДЕМОКРАТ МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБОО 54

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА 63

СДМЭХ-НЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖСЭН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА 70

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026

ХАВРЫН ЧУУЛГАН

79
ӨДӨР ЧУУЛСАН

35
НЭГДСЭН ХУДАЛДААН

127
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХАВРЫН ЧУУЛГАНЫ ОНЦЛОГ



2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурал нийт 35 удаагийн нэгдсэн хуралдаан, 127 удаагийн Байнгын хорооны хуралдаан зохион байгуулж, 278 хууль, тогтоомж баталлаа. Чуулганаар эдийн засаг, бизнесийн орчны шинэчлэл, төрийн бүтээмж, уул уурхай, боловсрол, эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, шинжлэх ухаан, байгаль орчин, нийгмийн хамгааллын салбарын эрх зүйн шинэчлэлийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, иргэн төвтэй, нээлттэй парламентын бодлогын шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн чухал шийдвэрүүдийг гаргав.

278
ХУУЛЬ, ТОГТООМЖ БАТЛАВ

Анхдагч хууль
18

Хуулийн шинэчилсэн найруулга
2

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
188

Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хууль
7

Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль
5

Улсын Их Хурлын тогтоол
58

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

Төсвийн байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд хаврын ээлжит чуулганы хугацаанд

17 УДАА ХУРАЛДАЖ
БУСАД БАЙНГЫН ХОРООДТОЙ
7 УДААГИЙН ХАМТАРСАН
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛЖ
НИЙТ **67** АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭВ.

Хуралдаанаар **31** хуулийн төсөл,
Улсын Их Хурлын **7** тогтоолын төсөл,
Байнгын хорооны **7** тогтоолын төсөл хэлэлцэж,
5 зөвшилцөх асуудал, хяналт, шалгалтын
6 тайлан, яам, агентлаг, харьяа байгууллагын
2 тайлан, мэдээллийг сонсон хэлэлцлээ.



ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Эдийн засгийн байнгын хороо 2026 оны хаврын чуулганы хугацаанд

16 удаа хуралдаж, бусад Байнгын хороодтой хамтран **5** удаа хуралдсан байна.

5 хууль болон хамт өргөн мэдүүлсэн **116** хуулийн төсөл, Улсын Их Хурлын **12** тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлав.





УИХ-ын намрын чуулганы хугацаанд МАН-ын бүлгийн хурал

16 удаа хуралдаж
38 асуудлыг хэлэлцэж
18 шийдвэр гаргалаа.

ПАРЛАМЕНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ, ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИН АЖИЛЛАВ.

Парламентын үйл ажиллагааг иргэдэд илүү хүртээмжтэй, нээлттэй болгох зорилтын хүрээнд хууль тогтоох үйл ажиллагааны цахим шилжилт, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх шинэчлэлийг дэмжин ажиллав.


Энэ хүрээнд **“Нээлттэй парламент”** цахим үйлчилгээг **e-Mongolia** платформд нэвтрүүлж, хоёр сая гаруй иргэн парламентын үйл ажиллагаа, хууль тогтоох үйл явцын талаарх мэдээллийг нэг цонхоор авах нөхцөл бүрдэв. Мөн **“УИХ таныг сонсож байна”** цахим үйлчилгээг нэвтрүүлснээр иргэд, аж ахуйн нэгжүүд хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудал, өөрчлөлтийн санал, санаачилгаа цахимаар Улсын Их Хуралд хүргүүлэх, хууль тогтоох үйл ажиллагаанд шууд оролцох боломжтой болов. Ингэснээр иргэдийн оролцоог зөвхөн өргөдөл, гомдол гаргах уламжлалт хэлбэрээр хязгаарлах бус, бодлого, хууль тогтоомжийн боловсруулалтад санал өгөх, оролцох шинэ хэлбэрийг төлөвшүүлэхэд ахиц гарлаа.

Түүнчлэн **parliament.mn** цахим системийг шинэчилснээр хууль тогтоомжийн хэлэлцүүлэг, санал хураалтын үр дүн, Улсын Их Хурал болон Байнгын хороодын хуралдааны ирц, гишүүн бүрийн санал хураалтаар илэрхийлсэн байр суурийг бодит цагийн горимоор олон нийтэд нээлттэй мэдээлэх тогтолцоо бүрдэв. Чуулганы шууд дамжуулалтын үеэр QR код ашиглан тухайн үед хэлэлцэж буй асуудлын талаарх мэдээлэлтэй танилцах, байр сууриа илэрхийлэх боломжийг бий болгосон нь парламентын үйл ажиллагааны ил тод байдал, иргэдийн мэдэх эрх, олон нийтийн хяналтыг цахим орчинд бодитоор хэрэгжүүлэх шинэ нөхцөлийг бүрдүүллээ.

Хэрэгжүүлсэн цахим шинэчлэлийн үр дүнд иргэд өөрсдийн сонгосон төлөөлөгчийн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцоо, хуралдааны ирц, санал хураалтаар илэрхийлсэн байр суурийг бодит цагийн горимоор хянах боломж бүрдэж, парламентын үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх институцийн тогтолцоог шинэ шатанд гаргалаа.

2026 оны хаврын ээлжит чуулганы статистикаар Улсын Их Хурлын **126 гишүүнээс 6 гишүүн 100 хувийн ирцтэй, 5 гишүүн 50 хувиас доош ирцтэй** ажилласан бөгөөд гишүүдийн дийлэнх нь **75-89** хувийн ирцийн ангилалд багтаж байна. Эдгээр мэдээллийг бодит цагийн горимоор иргэдэд нээлттэй болгосон цахим шинэчлэл нь гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, парламентын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, сонгогчдод өөрсдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлсэн бодит үр дүнтэй шинэчлэл болж байна.





ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ЭХЧҮҮДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛЖ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛДЭГ УРАМШУУЛАЛ, ДЭМЖЛЭГИЙН ТОГТОЛЦООНД БҮРЭН ХАМРУУЛНА

ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ



2025.06.24
УИХ-д өргөн мэдүүлсэн

2025.07.04
Үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн

2025.05.29
Эцэслэн баталсан

Миний бие Улсын Их Хурлын эмэгтэй гишүүн, таван хүүхэдтэй ээжийн хувьд хүүхэд, гэр бүл, эмэгтэйчүүдийн хөгжил, нийгмийн баталгааг дэмжих бодлогыг тууштай хэрэгжүүлж ирсэн. Энэ хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Б.Уянга, С.Эрдэнэбат, С.Эрдэнэболд нарын хамт “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж, УИХ-ын гишүүн О.Саранчулуунаар ахлуулсан ажлын хэсэг уг төслийг нэгдсэн чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэн ажилласнаар 2026 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэн эцэслэн батлууллаа.

Уг хууль нь 2027 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн хэрэгжиж эхлэх бөгөөд өмнө нь 1 нас хүргэлгүй хүүхдээ алдсан шалтгаанаар одонгоо авч чадаагүй эхчүүд одонгоо авах боломжийг бүрдүүлсэн юм.

Энэхүү хууль нь олон хүүхэдтэй эхчүүдийн нийгэмд гүйцэтгэж буй үүргийг өсгөж чаддаггүй гэх үндэслэлээр ялгаварлахгүй байх, хүүхдийн эрхийн зөрчлийг арилгах, гэр бүлийн үнэ цэнийг дэмжих, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх хөдөлмөрийг бодлогын түвшинд үнэлэх, хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг хангах чухал ач холбогдолтой шийдвэр боллоо.

ХУУЛЬ БАТЛАГДСАНААР 38.000 ГАРУЙ ЭХ ШИНЭЭР ОДОН АВНА



Монгол Улсад жил бүр дунджаар **75,000-80,000** хүүхэд шинээр мэндэлдэг;



Нийт төрөлтийн **3-4** орчим хувьд хүүхэд **1** нас хүрэхээс өмнө нас барж, мөн тооны ээжүүд одон болон одонгийн урамшуулалд хамрагдаж чаддаггүй;



Энэ нь ойролцоогоор жилд **2,500-3,000** эх хүүлийн хязгаарлалтаас үүдэн тэгш эрхээ эдлэх боломжоо алдаж буй хэрэг;



Хууль хэрэгжсэнээр Алдарт эхийн нэгдүгээр одон **10,154** ээж;



Алдарт эхийн **2** дугаар одон **27,100** ээж авна гэсэн урьдчилсан тооцоо бий.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЖИЛТИЙН ТӨРӨЛЖИЛТ, ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААГ ШИНЭЧЛЭН ЗОХИЦУУЛНА.

ХӨДӨӨ АЖ АХУЙН
ТУХАЙ ХУУЛЬ

УИХ-ын гишүүн М.МАНДХАЙ нарын бусад гишүүдийн хамтаар Хөдөө аж ахуйн тухай анхдагч хуулийн төслийг санаачлан УИХ-д өргөн мэдүүлж, 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар эцэслэн батлууллаа. Уг хууль нь 2027 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлнэ.



2025.06.19
УИХ-д өргөн мэдүүлсэн

2025.10.02
Үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн

2026.06.19
Эцэслэн баталсан

ХУУЛЬ БАТЛАГДСАНААР

- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийн төрийн урт, дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх, нөөц ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.
- Хүн амыг хөдөө аж ахуйн гаралтай гол нэрийн баталгаат хүнсээр, дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр тасралтгүй хангах боломжийг бүрдүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх төрийн дэмжлэгийн чиглэл, хэлбэр тодорхой болох ба хөдөө аж ахуйд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж, үр өгөөж сайжирна.
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд, бүтээгдэхүүний чанартай уялдсан үнэ тогтож, үнийн өсөлт болон үнэгүйдлээс сэргийлэх ба инфляцид хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнийн нөлөөллийн эзлэх хувийг бууруулах нөхцөл бүрдэнэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн эрсдэлийн үнэлгээ хийх тогтолцоо тодорхой болно.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлэх төрийн дэмжлэгийн чиглэл, хэлбэр тодорхой болох ба хөдөө аж ахуйд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэж, үр өгөөж сайжирна.
- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах, зах зээлд нийлүүлэх өртгийн сүлжээ, бэлтгэл, нийлүүлэлт өргөжиж, хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулна.
- Дотооддоо үйлдвэрлэх боломжтой хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний импорт буурч, хот, суурины орчим болон тариалангийн бүс нутагт эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэл хөгжинө.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн нийгмийн өмнө хүлээх эрх, үүрэг, хариуцлага тодорхой болж, тус салбарт төр, хувийн хэвшил, иргэний нийгэм, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагаа бэхжинэ.
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн харилцааг зохицуулсан харилцан уялдаа холбоо бүхий хуулийн зохицуулалт бий болж, эдийн засгийн хөшүүрэг, үр өгөөжийн бүртгэл, хяналттай болгоно.

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛНА.

ХҮНСНИЙ
ТУХАЙ ХУУЛЬ

УИХ-ын гишүүн М.МАНДХАЙ нарын бусад гишүүдийн хамтаар Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан УИХ-д өргөн мэдүүлж, 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар эцэслэн батлууллаа.

ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР

1. Хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо иж бүрэн цогц байдлаар хэрэгжиж, хүнсний баталгаат байдал сайжрах төдийгүй хүнсний экспортын чанар сайжирч, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ.
2. Хүнсний хяналтын тогтолцоог оновчтой болгосноор хүнсний сүлжээнд бүхэлд нь буюу хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл, хүнсний үйлдвэр, тээвэр логистик, гадаад, дотоодын хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, түгээлт, хэрэглэгчийн хүнсний хэрэглээнд тавих хяналт сайжирна.
3. Хүн амыг шим тэжээллэг, чанартай, баталгаатай хүнсээр хангах боломж нэмэгдэж, халдварын бус өвчлөл буурч, түүнтэй холбогдох зардал багасна.
4. Хэрэглэгч бодит мэдээлэлд тулгуурлан сонголтоо хийх чадвар, дадал төлөвшихөөс гадна хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлага дээшилж, хүнсний баталгаа сайжирна.
5. Төр, хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлтаар салбарын хүний нөөцийг чадавхжуулснаар хүнсний сүлжээний бүхий л үйл ажиллагаа мэргэжлийн удирдлагаар хангагдах нөхцөл бүрдэнэ.



2025.06.19
УИХ-д өргөн мэдүүлсэн

2025.10.02
Үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн

2026.06.26
Эцэслэн баталсан

САНХҮҮГИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГАД НИЙЦҮҮЛНЭ.

САНХҮҮГИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ



Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг УИХ-ын гишүүн **Б.Заяабалын** хамт санаачилж УИХ-д өргөн мэдүүлсэн. Уг хуулийн төслийг 2026.04.10-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжиж хуулийн төслийг нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн **Л.Соронзонболд** ахалж, гишүүдэд Р.Батболд, Н.Батсүмбэрэл, М.Мандхай, Г.Очирбат, А.Ундраа, Г.Уянгахишиг, П.Батчимэг, Ц.Баатархүү, М.Энхцэцэг нар ажиллаж байна.

Энэхүү хуулийн төсөл нь Хадгаламж зээлийн хоршоог зах зээлийн өнөөгийн чиг хандлагад нийцүүлж, олон улсын сайн туршлагад тулгуурлан Санхүүгийн хоршоо болгон хөгжүүлэхэд чиглэж байна. Үүний үр дүнд хоршоо нь зөвхөн гишүүдийн санхүүгийн хэрэгцээг хангахаас гадна нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг бүрэн дэмжих, мөн хөдөө аж ахуйн орны онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх боломжтой болох юм.

ХУУЛЬ БАТЛАГДСАНААР



САНХҮҮГИЙН ХОРШООНЫ 3 ДАВХАР ХАМГААЛАЛТ

НӨӨЦИЙН САН

Байвал зохих = Нийт хөрөнгө 3%

ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Хураамж: Жилд нэг удаа нийт хөрөнгө 0.25%

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛ

20 сая хүртэл төгрөг хураамж: нийт хадгаламж 0.125% Улсаас эхлэлтийн хөрөнгө: 5 тэрбум төгрөг

Санхүүгийн хоршооны салбарын нэгдсэн дэд бүтэц буюу тогтворжуулалтын сан, хадгаламжийн даатгал зэрэг хамгаалалтын олон давхаргат тогтолцоог олон улсын түвшинд нийцсэн байдлаар үе шаттайгаар нэвтрүүлснээр:

төрд үүсэх дарамтгүйгээр санхүүгийн хоршооны салбарыг тогтвортой хөгжүүлэх

Санхүүгийн хоршооны засаглал, санхүүгийн тайлагнал, технологийн дэвшил, цахим шилжилттэй холбоотой өөрчлөлтүүдийг тусгаж, ашгийн төлөө бус хуулийн этгээд байх нарийвчилсан зохицуулалтууд хийгдсэнээр:

санхүүгийн хоршооны зах зээлийн тогтвортой байдлыг хангах

БОЛОМЖ БҮРДЭНЭ

- Зах зээлийн цаашдын өсөлтийн нөхцөлийг бүрдүүлэх, гишүүн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах механизм боловсронгуй болохоос гадна зээлийн хүү буурах, бичил банкны эрх зүйн орчин бүрдүүлэх ач холбогдолтой.
- Санхүүгийн хоршоогоор дамжуулан иргэдэд санхүүгийн боловсрол олгож, зөв дадал хэвшил суулгаснаар төв газраас алслагдсан орон нутгийн иргэдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, сүүдрийн эдийн засаг, “мөнгө хүүлэгчид”-тэй тэмцэхэд тусална.
- Хоршооноос үйлчилгээ авах шаардлагатай, боломжтой бүхий л хүнд хүрч үйлчлэхийг зорьдог гишүүддээ ойр байгууллага тул хоршооноос үүссэн “ашиг” тухайн орон нутагт, гишүүддээ үлдэж, орон нутгийг хөгжүүлнэ.
- Санхүүгийн хоршоо нь гишүүдийн хэрэгцээг хангах зорилгоор бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, орон нутгийн хөгжил, ногоон санхүүг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлснээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, байгаль орчныг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулна.
- Санхүүгийн хоршооны үйл ажиллагааны цар хүрээ өргөжих, санхүүгийн шинэ үйлчилгээ бий болох, санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх, гишүүн төвтэй зохицуулалтын орчин бүрдэнэ.



ТӨСВИЙН БОДЛОГОО БИЧИЛ БИЗНЕСИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЧИГЛҮҮЛБЭЛ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ АЙЛ БОЛГОНЫ ХААЛГААР ОРНО

Банк бус санхүүгийн байгууллагын хадгаламж зээлийн хоршооны гишүүн байх эрхийг хааснаар хоршооны бусад гишүүд дундын хадгаламжийнхаа хөрөнгөөс бага хүүтэй зээл авч, бизнесээ хөгжүүлэх, өргөжүүлэх боломжийг санхүүгийн хоршооны хуулиар олгоно.

ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗЭЭЛИЙН ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ХАМГААЛАЛТЫН ДАВХАР ТОГТОЛЦОО 3 ДАВХАР ШАТЛАЛТАЙ БОЛЖ БАТАЛГААЖИНА


Одоо мөрдөгдөж буй Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг шинэчлэх болсны учир юу вэ?

Монгол Улс Хадгаламж зээлийн хоршооны тухай хуультай болохоос өмнө Хоршооны тухай хуулиар энэ чиглэлийн харилцааг зохицуулж ирсэн. Энэ үе тусгайлсан зохицуулалтгүйн улмаас олон хүн хөрөнгө, мөнгөөр хохирсон, үнэт амь эрсэдсэн гашуун сургамжийг бидэнд үлдээсэн юм. Энэ нөхцөл байдлыг зохицуулахаар Хадгаламж зээлийн хоршооны хуулийг 2015 онд баталж, хоршоодыг бүртгэлжүүлэх, тэдгээрт тавих шалгуур үзүүлэлт болон төрийн хяналтад үйл ажиллагаагаа явуулах зохицуулалтуудыг хуульчилж байв. Үүнээс хойш дорвитой өөрчлөлт оролгүй 11 жил болоход Монгол Улс төдийгүй дэлхийн зах зээлд крипто валютаас эхлэн олон төрлийн цахим арилжаа, худалдааны зохицуулалтууд орж ирлээ. Үүнтэй уялдуулж анхдагч санхүүгийн зах зээл болсон хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг дэлхийн жишиг стандартад нийцүүлж, олон улсын байгууллагуудай хамтарч ажиллах, тусламж дэмжлэг авах, үйл ажиллагаагаа өргөтгөх боломж гарцыг нээсэн эрх зүйн зохицуулалт шаардлагатай болсон юм. Иймээс миний бие олон улсын байгууллагатай хамтран 3 жилийн турш хийсэн судалгаанд дүн шинжилгээ, үнэлгээ хийсний үр дүнд хамгийн боломжтой хувилбарыг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн.

Хуулийн нэршлийг Санхүүгийн хоршооны хууль болгон өөрчилсний шалтгаан юу вэ?

Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа хадгаламж байршуулах, зээл авахад чиглэдэг. Үүнийг мэргэжлийн даатгалын болон санхүүгийн зах зээлийн үйлчилгээгээр мөнгөн хөрөнгийн урсгал тооцооны хэрэгсэл болгох боломжоор ханган өргөжүүлэх, нөгөөтэйгүүр “Хадгаламж зээлийн хоршоонд мөнгө хадгалуулах нь чононд хонь хадгалуулахтай адил” гэж ерөнхий боловсролын сурах бичгээр дамжин нийгэмд буй болсон хэвшмэл ойлголт, санхүүгийн зах зээл дээрх хамгийн бичил нэгжийнхээ нэр хүндийг шавар шавхайтай хутгаж хаяснаа залруулахын тулд нэршлийг нь өөрчлөхөөс эхэлье гэж үзсэн. Боловсролын яаманд 7-р ангийн Дүрслэх урлагийн сурах бичгийг зах зээлээс татан авч, дахин гаргах боломжгүй гэдгийг мэдэгдсэн.

Монгол Улсад
172
хадгаламж зээлийн хоршоо байдгаас хамгийн том нь
6000
гишүүнтэй.



Үүний нийт хөрөнгийн 90 гаруй хувь нь
11
хүний нэр дээр байдаг

Хуульд тусгасан гол зохицуулалтуудаас онцолбол?

ХЗХ-нд эргэлдэж буй мөнгөн хөрөнгө баталгаатай, найдвартай болох боломжийг олгож байгаа. Хоршоонд гишүүнээр элссэн хүн бүрийн хадгаламж давхар даатгалаар хамгаалагдах тогтолцоог бүрдүүлнэ. Энэ бол хадгаламж эзэмшигчийн эрхийг хамгаалж байгаа хувилбар юм. Дээрх тоон мэдээлэл нь газар нутаг, мэргэжлийн холбоод, ямар нэгэн сонирхлын бүлгээр ангилагдаагүйгээс болж улс орон даяар банк шиг зээл олгож байна гэсэн үг. Гэхдээ зээлийн хүү маш өндөр бөгөөд тодорхой хэмжээнд хууль эрх зүйн зохицуулалтаар хязгаарлахаар оролдож байгаа ч үр дүнд хүрч чадахгүй л байна. Иймд хоршооны гишүүн нэг л гишүүний үүрэгтэй байх бөгөөд заавал хадгаламжтай байхыг зүйлчилж байгаа. Мөн хурлын ирцээ бүрдүүлэх нь гишүүдийн хувьд хүндрэлтэй байдаг гэж ярьдаг. Үүнийг цахимаар хуралдах боломжтой болгон шийдсэн.



2.2 САЯ ТӨГРӨГИЙН ДУНДАЖ ОРЛОГОТОЙ АЙЛ 1 САЯ ТӨГРӨГИЙН ХУДАЛДАН АВАЛТ ХИЙЖ ЧАДДАГ БОЛСОН ЦАГТ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛД АХИЦ АВЧИРНА

Банк бус санхүүгийн байгууллага нь хадгаламж зээлийн хоршооны гишүүн байж болох эрх зүйн орчин нь арилжааны банкнаас авсан зээлээ хадгаламж зээлийн хоршоогоор илүү өндөр хүүтэй эргэлдүүлэх давхар хүүлэлтийн системийг нээж өгсөн байдаг. Иймд уг системийг хаахын тулд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авах замаар хоршооны гишүүн байхыг хориглохоор хуулийн төсөлд тусгасныг онцолмоор байна. Өнөөдрийн санхүүгийн тогтолцоо хэрэглээндээ таарсан зээлийг банк, түүнээс арай давсныг нь банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, бүр боломжгүй бол аппликэйшнээс зээл авах боломжийг бий болгосон нь иргэдийг зээлийн дарамтад оруулах үндэс болоод байна. Энэхүү нөхцөл байдлыг хязгаарлах нэг боломжийг уг хуулиар олгож байгаа. Тиймээс богино хугацаанд батлах шаардлагатай.

Хадгаламж хамгаалах тогтолцоог хэрхэн бүрдүүлж байгаа вэ?

Одоо байгаа хууль нэг л хамгаалалтын тогтолцоотой. Тэр нь Эрсдэлийн сан. Гэхдээ



биежээгүй, мөнгөжөөгүй бүртгэл төдий л байгаа юм. Зүй нь мөнгө дансанд биет хэлбэрээр байршиж байж эрсдэлээс хамгаалах ёстой шүү дээ. Өөрөөр хэлбэл гишүүддээ олгож байгаа хөрөнгөөс түсдаа хөрөнгө байж эргэлдэх ёстой. Хэрэгтэй үедээ бэлэн байж ашиглагдах ёстой. Гэтэл бодит байдал дээр нэг болчихоод сангийн хөрөнгө зээлээр гараад байгаа юм. Иймд түсдаа сантай болох замаар хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэхийг зорьж байна

Хуулийн төсөл УИХ-ын түвшинд аль шатандаа явна?

Хаврын чуулганы эхэнд хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн ч байнгын хороо анхны хэлэлцүүлгийг өнөөдрийг хүртэл хийгээгүй л байна. Гэтэл өргөн баригдмагцаа батлагдах гээд явж буй хуулиуд байна. Иргэдийн амьдралд хэрэгтэй, эдийн засгийн эргэлтэд чухал нөлөөтэй хуулийг хаврын чуулганд багтаан хэлэлцэхгүй ч ирэх намар нэн яаралтай оруулж ирэх ёстой.

Уг хууль батлагдсанаар санхүүгийн салбар хийгээд Монгол Улсын эдийн засагт ямар өөрчлөлт, дэвшил авчирна гэж харж байгаа вэ?

Улсын төсвийн 80-аад хувийг үүл үүрхайн салбарын орлого бүрдүүлдэг. Салбарын өсөлт буюу нүүрс, зэсний үнэ өндөр үед мэдээж эдийн засаг, ДНБ-ний өсөлт өндөр гарна. Гэвч энэхүү өсөлтийн нөлөө ард иргэдийн амьдрал дээр огт буудаггүй. Айл, өрхүүдийн хаалгаар ордоггүй. Макро эдийн засгийн өсөлт микро түвшиндээ очиж чадахгүй байгаа гол шалтгаан нь бид жижиг, дунд бизнес буюу жижиг санхүүгийн зах зээлээ хөгжүүлэхэд анхаарч чадахгүй байгаатай холбоотой. Энэ л жижиг хэмжээнд буй эдийн засгийн эргэлтийг дэмжих үйл явц маш чухал. Макро, микро эдийн засаг гэхээр их хол сэдэв мэт сонсогддог тул орлогын түвшингээр ялгаатай хүмүүсийн жишээн дээр тайлбарлая. Том компанид 20-30 мянган ам.долларын цалинтай хүмүүсийн хэрэглээ, худалдан авалт, мөнгөний урсгал гадагш л чиглэдэг. Харин 2 сая 200 мянган төгрөгийн дундаж орлоготой гэр бүл хувцас, хүнс, хэрэглээгээ монголд үйлдвэрлээгүй юм гэхэд монголд авчирч, зарж байгаа хүнээсээ л худалдаж авна. Монголдоо ресторан, цайны газраа л орно. Энэ чинь л дотоод эдийн засгаа дэмжиж буй хэлбэр байхгүй юу. Тиймээс уул уурхайн салбарын орлогын өгөөжийг жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ ялангуяа бичил бизнесийг хөгжүүлэхэд чиглүүлж чадаж гэмээ нь макро эдийн засгийн өсөлт айл өрх болгоны хаалгаар орох юм. Сарын цалингийнхаа 1 сая төгрөгөөр худалдан авалт хийж чаддаг болсон цагт энэ нөлөөлнө. Гэтэл бид үүнийхээ 120 мянган төгрөгийг инфляцад алдаад байгаа юм. Үүний ядаж 60-ыг нь алддаг байх боломжийг жижиг зах зээл, бизнес эрхлэгчдийн хүрээ томорч байж бий болгох боломжтой

ЗЭЭЛИЙН ЖИЛИЙН ХҮҮ

Арилжааны банк
16.6-17.2%

Банк бус санхүүгийн байгууллага
42-50%

Хадгаламж, зээлийн хоршоо
25-27%

Цахим аппликэйшн
36-96%

Эх сурвалж: Bun Эксперт ХХК, Expert сэтгүүл, дугаар 08, 2026 он.

ХҮҮХДИЙГ АМЬД ДОНОР БОЛГОХГҮЙ БАЙХ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООГ ХУУЛЬЧЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БИЙ БОЛГОВ



Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан “Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай” хуулийн төслийг Улсын Их Хурлын 2026 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталлаа.


Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн үеэр хүүхдийн эрх, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор хүүхдийг амьд донор болгохгүй байх зарчмын зөрүүтэй санал гаргаж, Байнгын хороо болон Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар дэмжүүлэн, хуулийн 8.3 дугаар зүйлд “Хүүхдээс ясны чөмөг, хүйн цус, хүйн эд, захын цуснаас бусад эрхтэн, эд эсийг шилжүүлэн суулгах зориулалтаар авахыг хориглоно” гэсэн шинэ зохицуулалтыг тусгууллаа.

Энэхүү зохицуулалт нь хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих зарчмыг үндэсний хууль тогтоомжид хэрэгжүүлж, хүүхдийн бие махбодын бүрэн бүтэн байдал, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн нэмэлт баталгааг бүрдүүлсэн ач холбогдолтой юм.

Шинээр батлагдсан хууль нь эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааны төрийн удирдлага, зохион байгуулалт, мэргэжлийн тогтолцоог шинэчлэн тодорхойлохоос гадна амьд болон амьгүй донор, реципиентийн эрх, үүргийг олон улсын жишигт нийцүүлэн зохицуулж, үндэсний хүлээлгийн жагсаалт, био банк, донорын цахим бүртгэл, оршуулгын тэтгэмж зэрэг шинэ эрх зүйн механизмыг бүрдүүлэв.

ХУУЛЬ БАТЛАГДСАНААР

Хууль хэрэгжиж эхэлснээр эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний хүртээмж нэмэгдэж, иргэд шаардлагатай эмчилгээг эх орондоо авах боломж өргөжихийн зэрэгцээ донорын тогтолцоо, хүний эрхийн хамгаалалт, ёс зүйн зохицуулалт, салбарын хүний нөөц, эсийн эмчилгээ болон био банкны хөгжлийн эрх зүйн үндэс бүрэн бүрдэх ач холбогдолтой юм.



Хууль санаачлагчид

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН АЖЛЫН ХЭСГҮҮДЭД ИДЭВХТЭЙ АЖИЛЛАЖ, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ АХЛАН АЖИЛЛАЛАА



11
АЖЛЫН ХЭСЭГТ АЖИЛЛАВ

Ахалсан ажлийн хэсэг
1

ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ
21 Аймаг
9 Дүүрэг
100 ГАРУЙ ОРОЛЦОГЧ

ADB ASIAN DEVELOPMENT BANK
European Bank for Reconstruction and Development

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАВ.





Хаврын чуулганы хугацаанд миний бие Улсын Их Хурлын даргын захирамж болон Байнгын хорооны тогтоолоор байгуулсан 11 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, үүнээс **“Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай”** хууль болон **“Нийтийн өмчийн тухай” хуулийн төслүүдийг** Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг **ахлан, дэд ахлагчаар** УИХ-ын гишүүн **П.САЙНЗОРИГ, О.НОМИНЧИМЭ**Г нар ажиллалаа.

Ажлын хэсгийн хүрээнд төрийн өмчийн засаглалын өнөөгийн нөхцөл байдалд иж бүрэн үнэлгээ хийж, төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулсан олон шатны зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Мөн 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн төрийн өмчийн асуудал хариуцсан байгууллагуудын оролцоотой үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг зохион байгуулж, орон нутагт тулгамдаж буй асуудал, санал, зөвлөмжийг нэгтгэн, хуулийн төсөлд тусган боловсруулсан болно.

Энэ хүрээнд **Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк** болон олон улсын зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, компанийн засаглал, өмчлөлийн бодлого, ил тод байдал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдал, төрийн өмчит компанийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын сайн туршлага, эрх зүйн зохицуулалтыг судлан хуулийн төсөлд тусгав.

“Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай” хууль УИХ-аар батлагдсанаар төрийн өмчит компани байгуулах үндэслэл, өмчлөлийн бодлого, засаглал, хяналт, ил тод байдал, ногдол ашгийн бодлого, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдлыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн зохицуулах эрх зүйн орчин бүрдэв.

Мөн төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчимд нийцүүлж, нийтэд санал болгох хувьцааны зохицуулалт, ил тод мэдээллийн тогтолцоо, олон нийтийн хяналт, компанийн үр ашиг, хариуцлагыг нэмэгдүүлэх шинэ тогтолцоо бий боллоо.

Энэхүү эрх зүйн шинэчлэл нь төрийн өмчит компаниудын засаглал, бүтээмж, хариуцлага, ил тод байдлыг шинэ шатанд гаргахын зэрэгцээ төрийн өмчийн үр өгөөжийг иргэдэд хүртээмжтэй хүргэх, үндэсний баялгийн удирдлагыг сайжруулах, хөрөнгө оруулалтын орчныг боловсронгуй болгох, төрийн оролцоог оновчтой болгох суурь нөхцөлийг бүрдүүлсэн томоохон институцийн шинэчлэл боллоо.



МОНГОЛ - ПОЛЬШИЙН ПАРЛАМЕНТЫН БҮЛГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улсын парламент хоорондын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, хууль тогтоох байгууллагуудын туршлага солилцоо, салбар хоорондын хамтын ажиллагааны боломжийг өргөжүүлэх хүрээнд Улсын Их Хурал дахь Монгол–Польшийн парламентын бүлгийн үйл ажиллагаанд оролцож, Бүгд Найрамдах Польш Улсад ажиллав. Айлчлалын үеэр хөдөө аж ахуй, эрүүл мэнд, уул уурхай, технологийн салбарын бодлого, зохицуулалт, шинэ технологи, туршлагатай танилцаж, хоёр улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцов.







2026.04.13

Монгол–Польшийн парламентын бүлгийн төлөөлөгчид БНПУ-ын Гадаад хэргийн дэд сайд ИГНАЦЫ НЕМЧЫЦКИ, Уур амьсгал, байгаль орчны дэд сайд бөгөөд Ерөнхий геологич КШИШТОФ ГАЛОС нартай уулзаж, хоёр улсын парламент хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрдэс баялаг, геологи, уур амьсгал, байгаль орчны бодлогын хамтын ажиллагааг хөгжүүлэх, эдийн засгийн харилцааг шинэ шатанд гаргах асуудлаар санал солилцов.









2026.04.15

Монгол–Польшийн парламентын бүлгийн төлөөлөгчид БНПУ-ын Сейм дэх Эмэгтэйчүүдийн эрхийн бүлгийн дарга ВАНДА НОВИЦКАТАЙ уулзаж, хоёр улсын парламент дахь эмэгтэйчүүдийн бүлгийн үйл ажиллагаа, хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх, парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэх, эмэгтэй манлайлагчдыг улс төр, бизнес болон бусад салбарт чадавхжуулах, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр туршлага солилцож, хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцов.



Монгол–Польшийн парламентын бүлгийн төлөөлөгчдийн хамт Эм, эмнэлгийн хэрэгсэл болон биоцидын бүтээгдэхүүний бүртгэлийн албаны Ерөнхийлөгч ГЖЕГОЖ ЦЕССАКТАЙ уулзаж, эм, эмнэлгийн бүтээгдэхүүний бүртгэл, чанарын хяналт, зохицуулалтын тогтолцоо болон хамтын ажиллагааны талаар мэдээлэл солилцов.



2026.04.15

БНПУ-ын Сеймийн дэд маршал ДОРОТА НЕЖЕЛТЭЙ уулзаж, парламент хоорондын хамтын ажиллагаа, хууль тогтоох байгууллагын туршлага солилцоо, парламентын найрамдлын бүлгүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцов.








2026.04.16




Монгол–Польшийн парламентын бүлгийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүний хамт KGHM группийн Полковице хот дахь Рудна зэсийн уурхайн үйлдвэрлэл, уурхайн техник, технологи, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай танилцаж, уул уурхайн салбарын хамтын ажиллагаа, дэвшилтэт технологийн туршлага судлав.







KGHM группийн ZANAM үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, уул уурхайн машин механизм, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлж буй технологи, үйлдвэрлэлийн туршлагыг судлав.







ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЛОББИ
БҮЛГИЙГ БАЙГУУЛАХ САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭВ



Хаврын чуулганы хугацаанд миний бие хүүхэд, гэр бүл, эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллыг төрийн бодлогын тэргүүлэх чиглэл болгон ажиллах зорилгын хүрээнд Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүдийн хамтаар **“Хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих бүлэг”**-ийг байгуулан ажиллаж байна.

Түс бүлгийг байгуулах санаачилгыг Улсын Их Хурлын **58 гишүүн** дэмжиж, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн талаарх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, энэ чиглэлээр өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, парламентын бодлогын уялдаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх нөхцлийг бүрдүүлэв.

Энэхүү бүлгийн үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын асуудлыг хууль тогтоох үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгон дэмжих, хүүхдийн эрхийг хангах, гэр бүлийг дэмжих бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх чухал механизмыг бүрдүүлэхэд чиглэв.









УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААН, БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААНД ИЛЭРХИЙЛСЭН

ОНЦЛОХ БАЙР СУУРЬ

МАН бол жендерийн хувьд, жендерийн тэгш эрхийг хангадаг хариуцлагатай нам. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд улс төрд манлайлж МАН-ын удирдлагын 40% нь эмэгтэйчүүд болж чадсанаараа онцлог байна.

МАН жендерийн бодлогоор шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг бэлтгэх шинэ систем бий болгоно.

Татварын бодлого бол зөвхөн орлого төвлөрүүлэх хэрэгсэл биш, харин эдийн засгийн өсөлтийг дэмжих, бизнес эрхлэх орчныг сайжруулах, иргэдийн амьжиргаанд эерэгээр нөлөөлөх төрийн бодлогын чухал хэсэг юм. Тиймээс НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босгыг 50 сая төгрөгөөс 400 сая төгрөг болгон нэмэгдүүлэх нь зүйтэй. Татварын бодлого иргэд, бизнес эрхлэгчдээ дэмжсэн, шударга, оновчтой байх ёстой.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1952 онд баталсан 102 дугаар конвенцод өндөр настны тэтгэврийн зохистой түвшинг хангах шаардлагыг тодорхойлсон байдаг. Манай улсын хувьд тэтгэвэр тооцох аргачлалаар тодорхой хувийг нөхөж байгаа боловч иргэдийн бодитоор авч буй тэтгэвэр, амьжиргааны хэрэгцээний түвшний хооронд зөрүү байсаар байна. Тиймээс зөвхөн төрийн санхүүжилтэд тулгуурлах бус, иргэд өөрийн нэмэлт хуримтлалаар ирээдүйн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх “Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль”-ийг дэмжиж байна.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль”-ийг баталж зөвхөн төрийн санхүүжилтэд тулгуурлах бус, иргэд өөрийн нэмэлт хуримтлалаар ирээдүйн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай байна.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээлснээр ямар ч төрлийн тамхи хортой. Тиймээс электрон тамхи онцгой албан татвар оногдуулах бүтээгдэхүүн мөн.





МАН-ын дарга,
Ням-Осорын **УЧРАЛ**

Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо намын ялалтын 40%-ийг нуруундаа үүрч байна. Цаашид шинээр элсэж буй гишүүдээ бэлтгэх, бэлтгэгдсэн эмэгтэйчүүдийг олж илрүүлэх, нам дотор зөв сонгон шалгаруулалтыг явуулах, бие биедээ хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсийг шат, шатны сонгуульд нэр дэвшүүлэхэд анхаарах нь чухал юм.



МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга,
Янгугийн **СОДБААТАР**

Эмэгтэй улс төрч, лидерүүдийгээ нийгэмд илүү таниулж, олон түмэнд тэр хүмүүсийн үзэл санаа, үйл ажиллагааг сурталчлан таниулах чиглэлд онцгой анхаарна.

> Нийгмийн даатгалын шимтгэл бол зөвхөн зардал биш, ажилтны ирээдүйн баталгаанд чиглэсэн нийгмийн хамгааллын тогтолцоо юм. Иймээс энэ тогтолцоог ажилтан, ажил олгогчийн аль алинд шударга, тэнцвэртэй, тогтвортой байдлаар эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй.

> Олон улсын жишгээс харахад тэтгэврийн сангууд нь зөвхөн иргэдийн ирээдүйн баталгаа төдийгүй эдийн засгийн урт хугацааны хөрөнгө оруулалтын чухал эх үүсвэр болж хөгжсөн байдаг. Тэтгэврийн хуримтлал нь эдийн засгийн эргэлтэд орж, бүтээмжтэй хөрөнгө оруулалтыг дэмждэг тогтолцоо болгох ёстой... Иймээс хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог хууль эрх зүйн хувьд тодорхой болгож, иргэдийн хуримтлалын эрх ашгийг хамгаалах нь цаг үеийн шаардлага гэж үзэж байна.

> Иргэдийн тэтгэврийн орлогын олон тулгуурт тогтолцоог бий болгож, ахмад настнуудын амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль"-ийн төслийг дэмжиж байна.

> "Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай" хуулийн төсөл батлагдсанаар төрийн өмчит компанийн үндсэн чиглэлийг Засгийн газар боловсруулж УИХ батална. Ингэснээр төрийн өмчит компаниуд төрийн бодлого, нийтийн ашиг сонирхолд нийцсэн чиг үүргээ хэрэгжүүлж, хувийн хэвшил үр ашигтайгаар хэрэгжүүлэх боломжтой зах зээлд үндэслэлгүй оролцох, үйл ажиллагааны давхардал үүсэх асуудлыг цэгцлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

> Засгийн газар АМНАТ-ын бууруулах асуудлыг хэлэлцэхдээ Эрдэнэт үйлдвэрийг хаалганы цаана үлдээлээ. Эрдэнэт үйлдвэрийн төлөх АМНАТ-ыг бууруулснаар ирээдүйд ашиглах Оюутын ордыг ашиглах "Цэвэр зэсийн үйлдвэр"-ийг ямар ч зээл авахгүйгээр өөрсдийн ашгаар барьж байгуулах боломжтой болно.

> Аливаа асуудалд бодит үнэн болоод зарчим байх ёстой. АМНАТ-ыг бууруулж олон улсын жишигт хүргэж байж, энэ салбарт гадаад дотоод хөрөнгө оруулалт татаж, чөлөөт өрсөлдөөн бий болгох боломж бүрдэнэ.





ОНЦЛОХ БАЙР СУУРЬ

> АМНАТ-ийг бууруулснаар зэсийн үйлдвэрийг ашгаар нь барих боломжтой.

> Эрдэнэт үйлдвэр ТӨХК-ийн төлөх АМНАТ-ыг 22% хэвээр үлдээсэн нь үйлдвэрийг цаашид ашигтай ажиллах биш хаалга үүдээ хаахад хүргэж байна.

> АМНАТ-ын бодлого зөвхөн татварын хувь биш, эдийн засгийн том зураглал, хөрөнгө оруулалт, иргэдийн амьжиргаатай уялдсан шийдвэр байх ёстой.

> Хөрөнгө оруулалтыг татахын тулд АМНАТ-ын бодлогыг тооцоо, судалгаанд суурилан шинэчлэх шаардлагатай байна. АМНАТ-ыг бууруулахад эсрэгээрээ ААН-ийн орлогын албан татвар нэмэгдэх учраас зөв тэнцвэржүүлбэл улсын орлого буурахгүй.

> АМНАТ-ыг бууруулаад 10 хувь болгосон ч “Эрдэнэт үйлдвэр” болон бусад шинэ төслүүд “Оюу толгой”-оос 2 дахин өндөр АМНАТ төлнө

> Уул уурхайн бодлогыг улс төржүүлэх бус, эдийн засгийн бодит тооцоо, үндэсний эрх ашигт тулгуурлан шийдвэрлэх нь зүйтэй!!

> АМНАТ өнөөдрийн энэ байдлаараа байх нь магадгүй Рио Тинтогийн төсөлд л ашигтай. Учир нь зэсийн салбарт цор ганц, хамгийн бага АМНАТ төлж байгаа. Цаашдаа энэ салбарт олон хөрөнгө оруулагч орж ирвэл Оюу толгойн гэрээний нөхцөлүүд шахагдаж эхэлнэ. Харин Эрдэнэт үйлдвэрт маш их хохирол бий болгож, боломжийг алдуулна. Эрдэнэт бол бараг 50 жил ажиллаад нөөц, бааз суурь нь бэхэжчихсэн болохоор энэ АМНАТ ийг даагаад явж байгаа болохоос биш шинэ төслийн хэмжээний АМНАТ-тэй явах боломжгүй.



ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН “ШИНЭ” ЭМБЛЕМ

Бидний уулзалт байдаг л нэг албан, байж болох хамгийн ёсорхуу өнгө аясаар эхэллээ. Тэр жимбийтэл бүсэлсэн хар торгон дээлнийхээ ханцуйн цаанаас цухуйх бугуйн цаг руугаа хяламхийнгээ

-Би 17:00 цагаас хуралтай юм л даа. Бидэнд хоёр цаг байна. Амжих уу? гэлээ.

Анх уулзаж байгаа хоёр хүний хувьд бие биенээ танихад арай л “хангалтгүй” хугацаа санагдаж байсан ч амнаас “Амжина аа” гэх сулхан авиа уначихав. Энэ мөчөөс хойш нэгэнт сувиад тараачихсан хүзүүний зүүлтийг нэг нэгээр нь түүж цуглуулах адил цаг хором бүрийг би шүүрч амжих хэрэгтэй боллоо. Надад түүний түүхийг мэдэхэд зориулагдсан ердөө 120 минут л оногдсон байв...

Тэр зургаан хүүхэдтэй айлын бага. Түүний аав Доржсүрэн цэргийн хошууч хүн. 1980-аад оны цэргийн айл ямар л байдаг билээ дээ. Социализмын сүүлч үе хэдий ч дээрээс тушаал ирвэл хэдэн ч хүүхэдтэй байсан чемоданаа чирээд л, төмөр орноос өөр тавилгагүй газар хоноглох зочин шиг бууж мордоод л, овоо нэг төвхнөж байтал үг дуугүй өөр газар руу томилж орхино. Тушаал авсан цэргийн ар гэр гэдэг ялгаагүй л үүрэг хүлээсэн цэрэг байдаг хойно. Аав ээжийнх нь хамгийн сүүлд томилогдсон газар нь Дорноговийн Сүмбэр сум буюу одоогийн Чойр хот байж таарчээ. Гэхдээ отгон охин нь аавыгаа Авдрантын хорих ангийн захирагчаар ажиллаж байхад Төв аймгийн Лүн суманд төрсөн аж. Тэгэвч тэр бага насаа өнгөрөөж, амьдралын гараагаа ч тэндээ л эхлүүлсэн Чойрын охин.

> *Гэтэл Д.Үүрийнтуяад дээрх хоёр чанар хоёулаа байгаад ч байх шиг. Энэ чинь л нөгөө өгөгдөл нь байсан юм биш үү дээ гэж бодож амжаад, хэтэрхий хурдан “дагаар орсон” мэт мэдрэмж төрөх үед өөрөөсөө санаа зовов. Ингэхэд Д.Үүрийнтуяа намайг өөртөө дагаар оруулж, байлдан дагуулахад хэр хугацаа зарцуулав аа!*
>
> *Ийн бодмогц би эрхгүй цагаа харлаа. Түүний хэлсэн хоёр цагийн хугацаа яг дуусч байв. Энэ үед Д.Үүрийнтуяа гишүүн мөн цагаа харах үест миний бие нэгэн зүйлийг нэхэн санасан юм. Тэр надтай ярилцах хугацаанд нэг ч удаа утсаа оролдож, эсвэл хэлсэн цаг нь хэтэрчих вий гэж байн байн цагаа харах үйлдэл нэг ч удаа гаргаагүйг санав.*

Ах эгч олонтойн хэргээр, тэр наймдугаар анги төгстлөө шал арчиж үзээгүй, аяга угааж үзээгүй, хоол хийх байтугай гурил ч зуурч мэдэхгүй өссөн гэнэ. Тэгсэн хэрнээ нэг их эрхлээд, хэлээ зажлаад байсан юм бас үгүй. Ер нь хичээлээс өөр зүйл хийдэггүй байсан юм даг аа. Улаан онцын л эзэн байж.

Харин эгч ах нар нь тусдаа гарсны дараа гараа цэврүүттэл шалны алчуур мушгиж эхлээд, “Амьдрал минь сайн уу?” гэж хэлжээ. 1990-ээд оны эхэнд тэдний амьдрал тийм ч

элбэг хангалуун байсангүй. Тэднийх ч гэлтгүй дээ, монголчууд тэр аяараа л өлөн зэлмүүн, дутах гачигдахын үерт хөл алдан үйж, үймж байсан цаг. Ажил төрөл олдохгүй, байр сав авах бэл бэнчингүйн улмаас ах эгч, хүргэн бэрүүд нь цөмөөрөө нэг гэрт чихэлдэж, аав ээжийнхээ тэтгэвэр болох 16 мянган төгрөгөөр л амь зууж байсан өдрүүд бий. Тэр үед нэг куртик 12 мянган төгрөгийн үнэтэй байлаа шүү дээ.

“Ээжийгээ нэг муу хүрэн хамбан дээлтэйгээ хэчнээн ч жил болсныг би мэдэхгүй байна” гэж хэлэх нэг л үг түүний амьдралын тэр зурвас үеийг бүрэн илэрхийлнэ. Хэдий хэлээгүй ч гэсэн, аав нь цэргийн бор ногоон цамцтайгаа л тэр өдрүүдийг туулсан байх даа гэж бодогдов.

Амьдрал ийм байхад айлын хэчнээн амин үр байлаа ч гар хуруугаа хөдөлгөж, гэр орныхоо ажил үйлд туслах хэрэгтэй болно. Ингээд Үүрийнтуяа охин ээжтэйгээ хамт төмөр замын вокзал дээр хоол зардаг болов. 10 дугаар ангиасаа харин үеийн хүүхдүүдээсээ ичиж нэрэлхэх зан сууж, ээжээсээ үлдэж хоцрох нь их болжээ. Удалгүй харин ТҮЦ нээснээр хичээлээ хийнгээ ээждээ туслах боломжтой болсон байна.

Хожим тэр сургуулиа төгсөж, төрийн албан хаагч болсон хойноо ч лангуу ажиллуулдаг байсныг сонсоод “Бидний л амьдрал даа” гэж бодож амжсан.

Д.Үүрийнтуяад гэхдээ бусдаас арай илүү нэг “өгөгдөл” байсан гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Тэр нь юу вэ гэж үү. Хичээл зүтгэл, мэрийлт, тууштай байдал, найрсаг зан, элдэг харьцаа, энэ бүхний аль нь ч биш. Ихэнх хүмүүс өөрийн ямар нэг амжилтыг эдгээр үгээр тайлбарлах гэдэг шүү дээ. Д.Үүрийнтуяагаас хэрэв өөрөөс нь асуусан бол ялгаагүй эдгээрийн аль нэгнийг л хэлэх байсан байх. Тиймээс би асуусангүй. Яах юм. Түүх нь өөрөө яриг!

Тэр бусдын, тэр тусмаа ажил олгогчийнхоо итгэлийг дэндүү хурдан олж чаддаг. Үнэлэгдэж чаддаг. Үүнийг нь төрөлхийн авьяас ч гэж болмоор. Мэдээж үүнд өөр нууц бий л дээ. Түүнийг хойно өгүүлье. Ямартай ч тэр Говьсүмбэр аймгийнхаа мэргэжлийн хяналтын газарт улсын байцаагчаар ажилд ороод, арван жилийн дотор л улсын ахлах байцаагч, хэлтсийн дарга, газрын дарга гээд дэвшээд явчихсан. Ажлаасаа гараад “Содмонгол” компанид ажилд орох гээд өргөдлөө өгтөл сонгон шалгаруулалтаар бас л салбарын дарга болоод “дээшээ” харайчихсан. Тэгээд сүүлд “Эрдэнэт” үйлдвэрт мөн л захирлын зөвлөхөөс санхүү эрхэлсэн орлогч захирал болж томорсон. Энэ бүхнийгээ тэр “Миний амьдралд дандаа нэг сайхан дарга нар таарч байсны буян” гэж тайлбарласан л даа. Бодоод үзэхэд, Говьсүмбэр аймгийн мэргэжлийн хяналтын газрын даргаар ажиллаж байсан Амарсайхан, “Содмонгол”-ын захирал Ц.Анандбазар, “Эрдэнэт” үйлдвэрийн захирал Х.Бадамсүрэн нар нэг хэвэнд цутгасан тархи оюунтай, зан авиртай хүмүүс байсан болохоороо л Д.Үүрийнтуяад цөм ижил хандаж үнэлээд байсан болж таарах уу. Тэдэнд нийтлэг байсан зүйл нь аливаа ажилтны ур чадварыг үнэлэх, таних “нүд” л заяасан хэрэг.

Д.Үүрийнтуяа бол алдаж болохгүй ажилтан, итгэл найдлага алдахгүй хамтран зүтгэгч байсан гэдэг нь бол маргаангүй юм билээ. Ганцхан жишээг нь ярья. Хоёр ч байсандаа илүүдэхгүй, энэ талын жишээ кэйс цөөдөө гэхийн зовлонгүй.

Тэр 28-тайдаа Говьсүмбэр аймгийн мэргэжлийнхяналтынгазрындаргаболж,гурван жил ажилласны дараа ажлаа өгчээ. Шалтгаан нь тухайн үед МАХН-ын Г.Шийлэгдамба МХЕГ-ын даргаар тавигдаж, бүх дарга нараа хувьсгалт намынхаа хүнийг тавина гэсэн тулгалтууд явж, мань хүн нэг ёсондоо шахаанд орж ажлаа өгөхөд хүрчээ. Ингээд Улаанбаатарт шилжиж ирэхээр шийдэн, шинэ ажил хайж яваад “Содмонгол” компанийн аудитор авах зарыг олж харж. Цалин нь 2 сая. Орон нутагт 700 мянган төгрөгийн цалинтай байсан хүнд хүсэл татсан цалин байлгүй яахав. Ингээд шалгалт





өгчихөөд Чойр руугаа буцаж явтал араас нь залгаад “Анандбазар захирал дуудуулж байна” гэж. Яваад очвол нөгөө Анандбазар нь ч уулзсангүй. Харин “Содмонгол” группын эдийн засгийн хэлтсийн дарга, гавьяат эдийн засагч Дашаа гэх эмэгтэй *“Та шалгалтад тэнцсэн. Гэхдээ ахиж шалгалт авна”* гээд эдийн засгийн чиглэлээр баахан шалгалт авсан байна. Ингээд үдээс хойш нь Анандбазар захирал хүлээж авч уулзаад аудиторoop биш, харин Эрдэнэт хотын салбарын даргаар ажиллах санал тавьжээ.

Д.Үүрийнтуяа саналыг шууд хүлээж авахад хэцүү байлаа. Гурван хүүхдийнхээ сургууль соёлыг яах билээ, нөхрийгөө ажлаас нь гаргаад очлоо гэхэд Эрдэнэтэд ажил төрөлгүй болно, амьдрах орон байр ч үгүй, таних мэдэх нэг ч хүнгүй гээд үнэн байдлаа л өчиж. Хариуд нь Анандбазар *“Санаа зоволтгүй. Нөхрийг чинь ГОК-д ажилд оруулж өгье. Хариуцсан салбарынхаа орлогыг одоо байгаагаас 2 дахин нэмэгдүүлж чадвал гурван өрөө байр өгнө”* гэж амалжээ.

Ингэж л Д.Үүрийнтуяа Эрдэнэт хотоор овоглох болжээ. Удалгүй тэр мөн “Эрдэнэт” үйлдвэрээр овоглох болно.

-Та тэгээд орлогыг нь 2 дахин нэмэгдүүлж чадсан уу?

-Чадалгүй яахав. Хоёр дахин байтугай, хэд дахин нэмсэн. Нэмээд Булган, Хөвсгөл аймагт салбар нээж өгсөн.

-Анандбазар тэгвэл амалснаа өгсөн үү?

-Өгөөгүй. Нөхрийг маань ажилд оруулах асуудал ч байгаагүй.

“За, одоо хангалттай”. Тийм дээ, хангалттай хичээсэн, гэвч зохих үнэлгээ, хүндлэлээ аваагүй газрын хаалгыг хэн ч байсан ингээд л хаана.

Д.Үүрийнтуяад хүртэх ёстой хүндлэлийг нь өгөх дараагийн газар нь бэлэн хүлээж

байлаа. Тэр бол улсын хамгийн том үйлдвэр “Эрдэнэт”. Тус үйлдвэрийн Ерөнхий захирлаар томилогдсон Х.Бадамсүрэн өөрийн багт орж ажиллах санал тавьж, санхүү, эдийн засаг хариуцсан зөвлөхөө болгожээ. Зөвлөхөөр ажиллаад хоёр жил болж байтал санхүү, эдийн засаг хариуцсан орлогчоор томилжээ. Өөрт нь дуулгаж, эсвэл зөвлөсөн ч үгүйгээр шууд л тушаалыг нь гаргачихсан байсан гэдэг. Ийм л одтой, азтай, эсвэл нөгөө өөр “өгөгдөлтэй” эмэгтэй гэдэг нь энэ байх.

Ер нь өөрөө л их даруухан, болох ёстой юм л болсон шигээр яриад суугаа болохоос биш, “Эрдэнэт” үйлдвэрийн дарга цэрэг болно гэдэг чинь жинхэнэ “алаан” байхгүй юу. Эмэгтэй хүн байтугай, эрчүүдийн алалддаг талбар. Гэтэл нэг шингэн дуутай, шавилхаан биетэй бүсгүй тэр зодоон дундуур жигтэйхэн жигдхэн цойлоод байна гэдэг гайхмаар явдал шүү.

Түүнийг анх ажлаа аваад очиход “Эрдэнэт” үйлдвэрийн нөхцөл байдал тийм ч сайн байгаагүй. Монгол Улсын Ерөнхийлөгч нь “Сааль нь дууссан үнээ” гэж зарлаж байлаа шүү дээ. 2016 оны балансаар “Эрдэнэт” үйлдвэр алдагдалтай гарсан байв. Тэр үед 184 тэрбум төгрөгийн татвар төлдөг байсан тус үйлдвэр Д.Үүрийнтуяаг ажиллах хугацаанд нийт 2.3 их наяд төгрөгийг төлсөн байдаг. Мөн жилдээ 32 сая тонн хүдэр боловсруулдаг байсныг өдгөө 40 сая тоннд хүргэсэн. Нөгөө үнээг чинь сааль сайтай үнээ болгоод “хувиргачихсан” байх нь. Тиймээс л түүнийг дотроо “Саальчин” гэж нэрлэчихэв.

“Эрдэнэт”-ийн санхүүгийн үрөгөөж нэмэгдсэн үйл явц нь олборлолт, экспортоо өсгөснөөс гэхээс илүүтэй олж бүй орлогоо хэмнэснээс бий болсон гэдгээрээ Д.Үүрийнтуяагийн нөлөө онцгой бий. Үр ашгийн ийм ялгааг хүмүүс тэр бүр анзаардаггүй. Менежментийн үр дүнд бий болсон нэмэлт орлого, ашиг гэж ойлгож болно. Сайн менежмент хийснээрээ ямар орлого олсон бэ гэдгийн хариулт нь, 2019 онд 23 тэрбум, 2020 онд 33 тэрбум, 2021 онд 14 тэрбум, 2022 онд 15 тэрбум төгрөгийн хэмнэлт хийжээ. Мөнгөн дүн жил бүр яагаад буурсны учир шалтгааныг асуухад, нөгөө хэмнэлт хийх боломжуудаа шахаад шахаад, сүүлдээ боломж нь буурч байгаагийн илэрхийлэл гэнэ.

Мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлсэн нэгэн жишээ. Д.Үүрийнтуяаг ажил авах үед манай улсын хамгийн том үйлдвэрийн мөнгөн хөрөнгийн 98 хувь нь зөвхөн Улаанбаатар банк, Худалдаа хөгжлийн банк гэх хоёрхон банкинд л байршиж байжээ.

> *Д.Үүрийнтуяад хүртэх ёстой хүндлэлийг нь өгөх дараагийн газар нь бэлэн хүлээж байлаа. Тэр бол улсын хамгийн том үйлдвэр “Эрдэнэт”. Тус үйлдвэрийн Ерөнхий захирлаар томилогдсон Х.Бадамсүрэн өөрийн багт орж ажиллах санал тавьж, санхүү, эдийн засаг хариуцсан зөвлөхөө болгожээ. Зөвлөхөөр ажиллаад хоёр жил болж байтал Санхүү, эдийн засаг хариуцсан орлогчоор томилжээ. Өөрт нь дуулгаж, эсвэл зөвлөсөн ч үгүйгээр шууд л тушаалыг нь гаргачихсан байсан гэдэг. Ийм л одтой, азтай, эсвэл нөгөө өөр “өгөгдөлтэй” эмэгтэй гэдэг нь энэ байх.*

Харилцах дансанд байршсан “Эрдэнэт” үйлдвэрийн бэлэн мөнгө гэсэн үг шүү дээ. Ямар ч хүү авдаггүй, эргээд дансандаа мөнгөтэй хэрнээ зээл аваад, зээлийн хүү төлдөг, ийм л нөхцөл байдалтай байж. Д.Үүрийнтуяа үүнийг маш өндөр эрсдэлтэй байна гэж дүгнээд, арилжааны банкуудын удирдлагуудыг дуудаж уулзан ***“Манай ажилчдад зээл олгохдоо хамгийн бага хүү санал болгосон банкинд “Эрдэнэт” үйлдвэр бэлэн мөнгөө байршуулна. Түүнээс гадна байршуулж буй мөнгөн хөрөнгөд хүүгийн түвшин амла”*** гэж хэлжээ. Яаж ч бодсон, Д.Үүрийнтуяагийн зөв байлаа. Нэгэнт манай мөнгөн хөрөнгө танайд эргэлдэж байгаа бол хүү төлөх ёстой биш гэж үү. Энд бага сага мөнгөний тухай биш, маш их бэлэн мөнгө байршуулах тухай ярьж байгаа. Үүний үр дүнд хүүгийн орлого гэх нэмэлт орлого олж эхэлсэн. Энэ нь 18 тэрбум төгрөг болжээ.

Мөн гэрээ хэлцэл болон маргаан шийдвэрлэснээс бий болгосон ашиг гэж бий. Д.Үүрийнтуяа 2017 оноос хойш нийтдээ 279 сая долларын үр ашгийг зөвхөн ашигтай хэлцэл хийсний үрээр бий болгосон гэсэн тоон үзүүлэлт байдаг аж. Үүнд төлөх ёстой төлбөрийг хүчингүй болгох, мөнгө нэхэмжилсэн маргааныг “Эрдэнэт”-ийн талд шийдвэрлэх, алдагдалтай гэрээг сайжруулах зэрэг олон ажил багтана.

Эцсийн дүндээ ковидын үед “Эрдэнэт” үйлдвэрээс 350 сая доллар буюу 1.1 их наяд төгрөгөөр иргэдийн тог цахилгаан, дулаан, хог хаягдал, усны төлбөрийг бүрэн даасан, дараа нь бүх сургууль, цэцэрлэг, дотуур байрны жорлон, ариун цэврийн байгууламжийн төсөлд зориулж 160 тэрбумыг гаргасан зэрэг үйл

хэрэгт Д.Үүрийнтуяагийн хувь нэмэр байсан. Алдагдалтай, асуудалтай, олсныг гарын салаагаар элс шиг урсгадаг, баруун солгойгүй идэж уудаг байсан бол хэчнээн том үйлдвэр ч гэлээ, иргэдэд очиж наалдах ийм үр ашиг бий болохгүй л байсан гэдэг нь бодитой.

Санхүүч, эдийн засагч хүний хувиар хийсэн ажлынх нь үр дүнг 2023 онд "Эрдэнэт" үйлдвэр түүхэндээ анх удаа балансын нэг ч зөрчилгүй гарсан үйл явдал илтгэнэ. Энэ бол аль ч газрын санхүүчдийн хувьд бахархах үзүүлэлт. Ажил мэргэжлийнхээ дүнгээр "Онц" авсан гэсэн үг.

Санхүүч, эдийн засагч хүний хувиар хийсэн ажлынх нь үр дүнг 2023 онд "Эрдэнэт" үйлдвэр түүхэндээ анх удаа балансын нэг ч зөрчилгүй гарсан үйл явдал илтгэнэ. Энэ бол аль ч газрын санхүүчдийн хувьд бахархах үзүүлэлт. Ажил мэргэжлийнхээ дүнгээр "Онц" авсан гэсэн үг.

Энэ бүхнийг зүгээр ганц бүсгүй хүн ирээд л хийчихсэн хэрэг бол биш л дээ. Сайн багийн ажиллагаа байсан нь мэдээж. Үүнийг нотлох үгийг ч Д.Үүрийнтуяа хэлсэн. *"Том дүн нь ерөөсөө Х.Бадамсүрэн захирлын хийсэн ажил л даа. Маш сайн баг, хамт олны хүчинд би хоёр их сургууль төгссөн юм шиг дадлага туршлага олох боломж надад олдсон. Юм сурах боломжийг би алдаагүй гэж боддог"* гэх түүний үгэнд өөртөө итгэх, өрөөлийг хүндлэх зарчим хамт шингэсэн байв.

...Энэ хугацаанд бидний хэн нь ч цаг руугаа харсангүй. Одоо бидний дунд байсан албан хана аль хэдийн нураад, оронд нь илэрхий хүндлэх хэв хүрээ үүссэн байв. Өмнөө суугаа хүнийхээ эмэгтэй гэдгийг ч мартаж орхисон байлаа. Ажлын төлөө махарсан, шөнө өдөр, ковид, салхи бороо гэхгүй зүтгэсэн, үүнийхээ ч үр дүнг цаасан дээр тоо болгож буулгаад үзүүлчихсэн, ихээ том эд баялаг, алт зэс, уул уурхай, хүнд үйлдвэр ярьсан, хэзээ язааны догь суучихсан хүн сууж байгаад эргэлзэхгүй боллоо. Бодлоо. "Энэ хүн чинь улс төрд санамсаргүй шидэгдээд ороод ирсэн чавхны чулуу биш юм байна"!

ГОК-ын орлогч дарга хүүхэн Хойд бүсэд нэр дэвшээд, эрчүүдтэй ана мана, ач тач үзэлцэж, УИХ-ын гишүүн болжээ л гэж сонсоод өнгөрснөөс, тэр нь улс төрд цахиур шиг гал маналзуулаад, часхийсэн дуу авиа гаргаад, намынхаа эмэгтэйчүүдийн тэргүүн эгнээнд, тэр дундаа бүр туг нь болоод мандчихна гэж төсөөлөөгүй. Эрх баригч МАН-ын дэргэдэх Социал демократ Монголын эмэгтэйчүүдийн холбооны Ерөнхийлөгчөөр сонгогдсон явдлыг хэлж байна.

Хамгийн сонирхолтой нь, хойд бүсэд Ц.Анандбазар нэр дэвших квотоо ч авч чадахгүй мултарч байхад, нэгэн цагт удирдлага доор нь ажиллаж байсан Д.Үүрийнтуяа ингэж од шүүрнэ гэдгийг таасан хүн нэг ч үгүй. Түүнийг "Эрдэнэт"-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэнгийн ойрын хүн, бараг хамаатан садан гэх яриа олныг сонссон ч өөрөө бол



үгүйсгэсэн. Нэг ёсондоо Х.Бадамсүрэнгийн "чавхны чулуу" гэдэг шошготой л УИХ-д орж ирсэн ч цэгцтэй, чигч үгтэй, зарчимтай, зангараг нөлөөтэй эмэгтэй улстөрчийн дүрийг амжилттай бүтээж явна.

Ер нь эмэгтэй улстөрчид зүүдэг эмблем, шошгоо жаахан бодмоор л болсон доо. Улс төрд эрэгтэй хүнийг "Тэрний хүн, энэний хүн" гэж ярих нь энгийн л үзэгдэл. Энэ бол фракцийн тухай яриа. Харин эмэгтэй хүнийг тийн нэрийдэхээр цаана нь огт өөр шилжсэн утга явж байдаг. Судлаач Д.Ж.Бистром олон нийт эмэгтэй улстөрчдийн гадаад төрх, хувийн амьдрал, жендэрийн үүргийг онцлон үзэж, бодлогын байр суурь, манлайллыг хоёрдугаарт тавьж

үзэх хандлагатайг тогтоожээ. Эдгээр хэвшмэл дүрслэлээс л “Хатан ухаан”, “Бурхан ааль”, “Дур булаам төрх” зэрэг үгс эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог илэрхийлэх болсон нь нууц биш.

Эмэгтэй улстөрчдийн оролцоо, нийгмийн үүргийг ард иргэдэд ээлтэй, саад хүндрэлийг амжилттай давсан, төсвийн менежментээ зөв хуваарилсан сайн жишгээр тодорхойлмоор санагддаг юм. Үүнд Д.Үүрийнтуяагийн дүр яг тохирно.

Манайханд нийтлэг нэг хандлага бий. Улстөрчдийг шийдэмгий, зоригтой, тэмцэгч гэх мэт чанараар үнэлэх гэдэг. Гэтэл эдгээр нь гол төлөв эрэгтэй хүнд ахиу байдаг чанарууд. Саяхан хийсэн “Koica”-гийн нэгэн судалгаагаар “Олон нийт нэг талаас зоригтой, үгээ дайчин гал цогтой илэрхийлдэг байх, нөгөө талаас даруу, төлөв төвшин байх гэсэн эсрэгцсэн чанарыг эмэгтэй улстөрчөөс хүлээж байна” гэсэн дүгнэлт гаргажээ. Эрэгтэйчүүдээс хүсдэгээсээ илүү ихийг эмэгтэй улстөрчдөөс хүсээд байна гэсэн үг л дээ.

Гэтэл Д.Үүрийнтуяад дээрх хоёр чанар хоёулаа байгаад ч байх шиг. Энэ чинь л нөгөө өгөгдөл нь байсан юм биш үү дээ гэж бодож амжаад, хэтэрхий хурдан “дагаар орсон” мэт мэдрэмж төрөх үед өөрөөсөө санаа зовов. Ингэхэд Д.Үүрийнтуяа намайг өөртөө дагаар оруулж, байлдан дагуулахад хэр хугацаа зарцуулав аа!

Ийн бодмогц би эрхгүй цагаа харлаа. Түүний хэлсэн хоёр цагийн хугацаа яг дуусч байв. Энэ үед Д.Үүрийнтуяа гишүүн мөн цагаа харах үест миний бие нэгэн зүйлийг нэхэн санасан юм. Тэр надтай ярилцах хугацаандаа нэг ч удаа утсаа оролдож, эсвэл хэлсэн цаг нь хэтэрчих вий гэж байн байн цагаа харах үйлдэл нэг ч удаа гаргаагүйг санав.

Энэ чинь л нэгдүгээрт, төлөвлөлт. Хоёрдугаарт төвлөрөл аж.

Мэдээж надад түүний тухай мэдээгүй олон түүх, хариулт авч амжаагүй олон асуулт үлдсэн. Гэхдээ юу гээч. Тэдгээрийг би ирээдүй цагт даатгая. Учир нь тэнд ч ялгаагүй, яг л алдаагүй ажилладаг цагийн механизм шиг Д.Үүрийнтуяа гэж хүний улс төрийн цаг чаг, чагхийн цохилсоор байхыг мэдэв.

Сэтгүүлч ***Д.ДАМДИНЖАВ***

Эх сурвалж: Гранд сэтгүүл №147.
2026 оны 06 сар.



ХОЙД БҮС

БАЙГАЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨРӨЛЖСӨН, *АЖ ҮЙЛДВЭРИЙН ДЭД БҮС*



“БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО” ХЭРЭГЖСЭНЭЭР:

Бүс, орон нутгийн эдийн засгийн чиг үүргийг оновчтой тодорхойлно;

Орчин үеийн шинэ суурьшлын бүс, хотуудыг байгуулна.

Үйлдвэр, үйлчилгээг хоршилт, төрөлжилт, дагналт, кластерын бодлогоор дэмжинэ;

Бүс дамнасан, салбар хоорондын уялдааг хангасан стратегийн төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;

Бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилна;

Байгалийн нөөц баялгийг зохистой, өгөөжтэй, хүртээмжтэй ашиглаж, хамгаалж, нөхөн сэргээнэ;

Бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэн, зах зээлийг тэлнэ;

БУЛГАН АЙМАГ

Хүн ам*	**60.6**
Газар нутаг	**48.7 мян.км²**
Аймгийн төв	**Булган**
Сумын тоо	**16**

ОРХОН АЙМАГ

Хүн ам*	**111.5**
Газар нутаг	**0.8 мян.км²**
Аймгийн төв	**Эрдэнэт**
Сумын тоо	**2**

ХӨВСГӨЛ АЙМАГ

Хүн ам*	**137.9**
Газар нутаг	**100.6 мян.км²**
Аймгийн төв	**Мөрөн**
Сумын тоо	**23**

** Үндэсний статистикийн хорооны 2025 оны мэдээлэл”*



Монгол Улсын нийт хүн амын **8.8** хувь хойд бүсэд оршин суудаг бөгөөд бүсийн ДНБ-ийг бүтцээр авч үзвэл **63.7%**-ийг үйлдвэрлэл, **17.7%**-ийг үйлчилгээ, **18.6%**-ийг хөдөө аж ахуй эзэлж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо **6.770**, дундаж цалин **1.7** сая.төгрөг бөгөөд нийт малын тоо **9.4** сая.толгой байна.

БҮСИЙН ТЭРГҮҮЛЭХ 5 ТӨСӨЛ:

- Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр барина. *(Орхон аймгийн Баян-Өндөр сум, Жаргалант сум)*
- Мөрөн нисэх буудлыг 4С ангиллын нисэх буудал болгон өргөтгөж, олон улсын нислэг хүлээн авах боломжийг судална
- Эгийн голын усан цахилгаан станц барина *(Булган аймаг, Хутаг-Өндөр сум)*
- Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлж, бүсүүдэд дадлага, үйлдвэрлэлийг бааз байгуулна *(Хөвсгөл, Булган аймаг)*
- ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургууль болон Мэдээлэл холбооны технологийн сургуулийг Орхон аймагт шилжүүлэх *(Орхон аймаг)*



УИХ-ЫН ГИШҮҮН

Доржсүрэнгийн ҮҮРИЙНТУЯА

Миний бие УИХ-ын хаврын чуулганы хугацаанд хууль тогтоох үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын зэрэгцээ улсын болон орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй салбарын бодлогын асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор тодорхой санал, санаачилга гарган ажиллалаа.

Хэрэгжүүлсэн бодлогын ажлууд нь Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, МАН-ын мөрийн хөтөлбөрийн зорилтод нийцсэн болно.

“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН ААНОАТ-ЫН 1 ХУВИЙН ХӨНГӨЛӨЛТ БОДИТ ҮР ДҮНГЭЭ ӨГЧ ЭХЭЛЛЭЭ.



“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ААНОАТ-ын 1 хувийн хөнгөлөлтийг үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж буй ОРОН НУТАГТ нь хөрөнгө оруулалт болгон зарцуулж, үр шимийг нь нутгийн иргэд бодитоор хүртдэг байх зорилгоор ДЭВШҮҮЛСЭН САНААЧИЛГЫГ минь тухайн үеийн Монгол Улсын Ерөнхий сайд Г.ЗАНДАНШАТАР, Сангийн сайд Б.ЖАВХЛАН нар дэмжиж ажилласанд чин сэтгэлийн талархал илэрхийлье.







Энэхүү санаачилгын үр дүнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн холбогдох зохицуулалтын дагуу нийт 80 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын бизнес төлөвлөгөөнд тусгуулан батлуулж, үүнээс 2026 онд 45.1 тэрбум төгрөг, 2027 онд 34.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр шийдвэрлүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Нийт хөрөнгө оруулалтаас Орхон аймагт 59.7 тэрбум төгрөг, Хөвсгөл аймагт 4.0 тэрбум төгрөг, Булган аймагт 0.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгасан бөгөөд боловсрол, нийгмийн хамгаалал, соёл, спорт, аялал жуулчлал, инженерийн дэд бүтцийн чиглэлээр нийт 10 төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

Орхон аймагт хэрэгжиж буй хөрөнгө оруулалт:

- Эрдэнэт хотын Цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, шинэчлэл
- Наадмын талбайн тохижилт, авто зогсоолын өргөтгөл
- Бурхан багшийн сэрэг дүр орчмын тохижилт
- Уурхайчин хорооллын сургууль, цэцэрлэг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв
- 11 дүгээр хорооллын авто замын бүтээн байгуулалт

Хөвсгөл аймагт хэрэгжих хөрөнгө оруулалт:

- Арбулаг сумын 150 ортой хүүхдийн дотуур байрны барилга
- Рэнчинлхүмбэ сумын дулаан, цэвэр усны шугамын шинэчлэл

Булган аймгийн хөрөнгө оруулалт:

- Бугат, Хангал сумдын спорт заалны засвар, шинэчлэл.

САНХҮҮЖИЛТ НЬ НЬ УДААШИРСАН, ГАЦСАН СУРГУУЛИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ СЭРГЭЖ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭВ



2026 оны улсын төсвийг хэлэлцэх үеэр Орхон аймгийн Говил, Рашаант багт баригдаж буй, 2020 оноос хойш санхүүжилтийн хүндрэлээс шалтгаалан зогсонги байдалд байсан 250 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын төсөвт тусгуулан шийдвэрлүүлж, улмаар барилгын ажлыг 2026 онд дахин эхлүүлснээр боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхэд, сурагчдын суралцах орчин, нөхцөлийг сайжруулах, олон жил үргэлжилсэн төрийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх бодит үр дүн гарлаа.

СУРГУУЛИЙН БАРИЛГА, 250 СУУДАЛ ОРХОН, БАЯН-ӨНДӨР СУМ, ГОВИЛ БАГ





СУРГУУЛИЙН БАРИЛГА, 250 СУУДАЛ ОРХОН, БАЯН-ӨНДӨР СУМ, РАШААНТ БАГ





ХОЙД БҮСИЙН ХАВДРЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОДЛОГЫН САНААЧИЛГА ХЭРЭГЖИЖ БАЙНА

Хойд бүсийн иргэдэд хавдрын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээний тусламж, үйлчилгээг орон нутагт нь хүртээмжтэй хүргэх, төвлөрсөн эмнэлгийн ачааллыг бууруулах, бүсчилсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Хойд бүсийн зөвлөлийн хуралдааны үеэр миний дэвшүүлсэн санаачилгын дагуу Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төвийг байгуулсан.



Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төв нь 2026 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих 192 нэр төрлийн оношилгоо, эмчилгээний багцын хүрээнд иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Үүний дотор хавдрын 17 төрлийн оношилгоо, эмчилгээний багцыг орон нутагт хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид уг үйлчилгээг 43 багц болгон үе шаттайгаар өргөжүүлэхээр ажиллаж байна.

Дэд төв байгуулагдсанаас хойш хавдрын анхны мэс засал болох элэгний VI–VII сегмент тайрах мэс заслыг 2026 оны 3 дугаар сарын 5-ны өдөр амжилттай хийж, бүсийн хэмжээнд хавдрын мэс заслын тусламж, үйлчилгээг нутагшуулан үзүүлэх эхлэлийг тавилаа.

Тус төв нь Хөвсгөл, Булган, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн нийт **525** мянга орчим хүн амд хавдрын нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг бүсчилсэн зарчмаар үзүүлэх хүчин чадалтайгаар байгуулагдсан. Өдөрт **500** хүртэлх амбулаторийн үзлэг, **30** хүртэлх хүнд химийн эмчилгээ хийх, **35** ортойгоор хэвтүүлэн эмчлэх боломжийг бүрдүүлснээр орон нутагт хавдрын тусламж, үйлчилгээг хүргэх төрийн бодлогын чухал суурь бүрдсэн.





АЛСЛАГДСАН СУМ БАГТ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХҮРТЭЭМЖ НЭМЭГДЭНЭ



Хөвсгөл, Булган аймгийн иргэд, орон нутгийн удирдлагаас алслагдсан сум, багуудад үүрэн холбоо, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний хүртээмж хангалтгүй байгаагаас төрийн үйлчилгээ авах, боловсрол, эрүүл мэнд, цахим үйлчилгээ ашиглах боломж хязгаарлагдаж байгаа талаар удаа дараа санал, хүсэлт ирүүлж байсан.

Эдгээр асуудлыг шийдвэрлүүлэх чиглэлээр холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллаж, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яаманд уламжилсны үр дүнд улсын төсвийн хөрөнгөөр Хөвсгөл, Булган аймгийн зарим сум, багт харилцаа холбооны дэд бүтцийг шинээр байгуулах, өргөтгөх ажил хэрэгжихээр шийдвэрлэгдсэн. Энэхүү ажил нь төрөөс баримталж буй бүсчилсэн хөгжил, цахим шилжилтийн бодлогын хүрээнд алслагдсан сум, багийн сүлжээний хүртээмжийг үе шаттай нэмэгдүүлж, суурь дэд бүтцийг бэхжүүлэх, иргэдийн төрийн болон нийгмийн үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны Сайдын 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/385 дугаар албан бичгийн хавсралт

Дэд бүтэц байгуулах байршлын мэдээлэл:

№	Хөрөнгийн эх үүсвэр	Аймаг	Сум	Баг, газрын нэр
1	УТХО 2026	Булган	Могод	Баянгол
2	УТХО 2026	Булган	Баян-Агт	3-р баг, Баянхайрхан, Хэрээтийн гозгор
3	УТХО 2026	Булган	Тэшиг	3-р баг, Далан
4	УТХО 2026	Булган	Бүрэгхангай	2-р баг, Цахт, Шар чулуут уул
5	УТХО 2026	Булган	Тэшиг	4-р баг, Эрэн, Буужав
6	УТХО 2026	Булган	Хишиг-Өндөр	3-р баг, Тэзг баг, Дервөлжин модны ой
7	УТХО 2026	Хөвсгөл	Рашаант	Их-Ац, Харганатын орой
8	УТХО 2026	Хөвсгөл	Жаргалант	Харгана, Ацын орой
9	УТХО 2026	Хөвсгөл	Жаргалант	Харгана, Бууралын орой
10	УТХО 2026	Хөвсгөл	Арбулаг	Хавтаг
11	УТХО 2026	Хөвсгөл	Цагаан-Уул	Тосон
12	УТХО 2026	Хөвсгөл	Цагаан-Уул	Хужирт
13	УТХО 2026	Хөвсгөл	Улаан-Уул	Мунгараг баг
14	УТХО 2026	Хөвсгөл	Ренчинлхүмбэ	5-р баг, Ёлт газарт
15	УТХО 2026	Хөвсгөл	Ханх	1-р баг, Тураг, Ходон
16	УТХО 2024-2025	Хөвсгөл	Түнэл	6-р баг
17	УТХО 2024-2025	Хөвсгөл	Эрдэнэбулган	2-р баг
18	УТХО 2024-2025	Хөвсгөл	Галт	Рашаант баг, Дуутын их уул
19	УТХО 2024-2025	Хөвсгөл	Жаргалант	Хөнжил баг, Хөвсын орой
20	УТХО 2024-2025	Хөвсгөл	Баянзүрх	Агар баг, Шар гозгор уул

ХОЙД БҮСЭД 57,3 ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ 2026 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР УЛСЫН ТӨСӨВТ ТУСГАГДЛАА.

2026 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хойд бүсэд нийт **193,943.0 сая** төгрөгийн өртөгтэй 27 шинэ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс **57,342.4 сая** төгрөгийг 2026 онд санхүүжүүлэхээр улсын төсөвт тусгав.

САЛБАР	НИЙТ САНХҮҮЖИЛТ /сая төгрөгөөр/	ҮҮНЭЭС 2026 ОНД
Онцгой байдлын салбар	8,544.7	2,178.9
Хууль зүйн салбар	22,771.7	7,282.0
Байгаль орчны салбар	388.3	388.3
ГБХНХ-ын салбар	8,653.9	3,400.0
Зам тээврийн салбар	94,055.7	24,770.9
Соёлын салбар	5,356.8	2,025.0
Хот байгуулалт орон сууцжуулалтын салбар	4,302.9	2,047.3
Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар	9,800.0	6,200.0
Эрүүл мэндийн салбар	40,069.0	9,050.0

ИРГЭДИЙН ТӨСӨВ 2026

Эх сурвалж: Сангийн яам

БУЛГАН АЙМАГ

Санхүүгийн дэмжлэг 14.5 тэрбум ₮

Суурь орлого 65.2 тэрбум ₮

Тэнцэл -14.5 тэрбум ₮

Суурь зарлага 79.7 тэрбум ₮

Орон нутгийн хөгжлийн сан 13.5 тэрбум ₮

ОРХОН АЙМАГ

Улсын төсөвт төвлөрүүлэх 107.0 тэрбум ₮

Суурь орлого 264.0 тэрбум ₮

Тэнцэл 171.7 тэрбум ₮

Суурь зарлага 92.4 тэрбум ₮

Орон нутгийн хөгжлийн сан 39.1 тэрбум ₮

ХӨВСГӨЛ АЙМАГ

Санхүүгийн дэмжлэг 56.4 тэрбум ₮

Суурь орлого 51.8 тэрбум ₮

Тэнцэл -56.4 тэрбум ₮

Суурь зарлага 108.2 тэрбум ₮

Орон нутгийн хөгжлийн сан 19.1 тэрбум ₮

ИРГЭДИЙН САНАЛ ХҮСЭЛТ

2026 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 182 санал, хүсэлт, өргөдөл, гомдол ирүүлснээс 78 бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж, 67 бичигт албан хариу хүргүүлэн, 33 бичиг шийдвэрлэгдэж, 4 бичиг судлагдах шатандаа байна.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.Үүрийнтуяа ↗

Монгол Ардын Нам · 4-р тойрог ·

Төсвийн байнгын хороо · Эдийн засгийн байнгын хороо

2026 онд Хаврын ээлжит чуулган (182)	2025 онд Намрын ээлжит чуулган (192)
2025 онд Хаврын ээлжит чуулган (160)	2024 онд Намрын ээлжит чуулган (150)
Бүгд (684)	

Өргөдөл	Санал	Хүсэлт	Гомдол	Сонодуулга	Шаардлага
50	14	118	0	0	0

192 ИРСЭН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

ТӨЛӨВ:

Холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилсан (78)		
Албан хариу хүргүүлсэн (67)	Шийдвэрлэгдсэн (33)	Судлагдаж буй (4)





ТӨРИЙН ОРДОНТОЙ ТАНИЛЦСАН ИРГЭДИЙН ТОО

2026

2026 оны хаврын чуулганы хугацаанд миний бие сонгогдсон тойргийн **382** гаруй иргэд, сонгогчдыг Төрийн ордонд хүлээн авч, уулзалт зохион байгуулан, хууль тогтоох үйл ажиллагаа болон тойрогт хэрэгжүүлж буй ажлаа танилцуулан ажиллалаа.

48 221 113

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

2026 оны эхний хагас жилд Хойд бүсийн иргэдийн хөдөлмөр, гавьяаг төрөөс үнэлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, дараах төрийн дээд шагналуудыг уламжилж олгууллаа. Үүнд: **“Монгол Улсын Гавьяат эдийн засагч”** цолоор Эрдэнэт хотын анхдагч илгээлтийн эзэн, ахмад санхүүч **С.НЯМЖАВ, “Монгол Улсын Хөдөө аж ахуйн гавьяат ажилтан”** цолоор “Орхон тариа” ХХК-ийн захирал **Л.ОТГОНБАТ, “Монгол Улсын Гавьяат эмч”** цолоор П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлгийн Ерөнхий мэс заслын тасгийн эрхлэгч **Ц.ЛОЧИН** нар тус тус шагнагдлаа.

Төрийн дээд одон, медалиар:

105 ИРГЭН удаа


Алтан гадас
56

Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон
16

Хөдөлмөрийн хүндэт медаль
33

Мөн Засгийн газрын болон салбарын шагналаар нийт 35 иргэн шагнагдсанаас салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр 28, жуух бичгээр 7 иргэн тус тус шагнагдсан байна.









ЗАСГИЙН ГАЗРЫН ШАГНАЛ
35

- Салбарын тэргүүний ажилтан **28**
- Салбар яамны жуух бичиг **7**

МОНГОЛ УЛСЫН АВАРГА МАЛЧДЫН ЦОЛ, **ТЭМДГИЙГ ГАРДУУЛАН ӨГЛӨӨ**



Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Мухар хөндий багийн малчин Бадамдоржийн **ЖАМБАЛДОРЖИЙН** гэр бүлд **“УЛСЫН АВАРГА МАЛЧИН”** цол тэмдгийг гардуулан өглөө.



Хөвсгөл аймгийн Арбулаг сумын малчин Амарбатын **ГАНЗОРИГИЙН** гэр бүлд **“УЛСЫН АВАРГА МАЛЧИН”** цол тэмдгийг гардуулан өглөө.



ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХӨТӨЛБӨР

Хойд бүсийн аймгуудын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн **“ХОЙД БҮСЭД ҮЙЛДВЭРЛЭВ”** хөтөлбөр хэрэгжүүлж байна.

Орхон аймгийн ЕБС-ийн сурагчдын бахархлыг төрүүлэх зорилготой **“ЭРИН ЗУУНЫ БАХАРХАЛ-ЭРДЭНЭТ”** хөтөлбөр хэрэгжүүлж байна.

1. Хойд бүсийн хүүхэд, залуусын ном уншлагын соёлыг дэмжих зорилгоор **“ОЮУНЛАГ ХОЙД БҮС”** хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
2. Хойд бүсийн аймгуудын бүх шатны ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдийг дэмжих **“ЭРГЭХ ХОЛБОО-ЭМЭГТЭЙ ТӨЛӨӨЛӨГЧИД”** хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
3. ЕБС-ийн сургуулийн сурагчид зориулсан **“БИ ИРЭЭДҮЙН ИНЖЕНЕР”** хөтөлбөр хэрэгжүүлж байна.

“ХОЙД БҮСЭД ҮЙЛДВЭРЛЭВ–2026” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Миний дэвшүүлсэн санаачлагын хүрээнд Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хамтран “Хойд бүсэд үйлдвэрлэв–2026” үзэсгэлэн худалдааг Эрдэнэт хотноо хоёр дахь жилдээ зохион байгууллаа.

Тус арга хэмжээ нь хойд бүсийн жижиг, дунд үйлдвэр, хоршоологч, өрхийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтын сувгийг өргөжүүлэх, бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засгийн идэвхжил, үйлдвэрлэлийг дэмжих зорилготой.

Үзэсгэлэн худалдаанд хойд бүсийн 100 гаруй үйлдвэрлэгч оролцож, хүнс, хөдөө аж ахуй, гар урлал, боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээ танилцуулан борлуулж, хөрөнгө оруулагч, худалдан авагчид болон бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааны шинэ боломжийг бүрдүүлдгээрээ онцлогтой юм.

Энэхүү арга хэмжээ нь бүсийн үйлдвэрлэгчдийн зах зээлийн хүртээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, үйлдвэрлэгчдийн харилцаа, түншлэлийг бэхжүүлэх, улмаар бүсчилсэн хөгжлийн бодлого, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжихэд хувь нэмэр оруулж байна.





“ОЮУНЛАГ ХОЙД БҮС” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД “ОЮУНЫ БЭЛЭГ–2026” НОМЫН АЯНЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭВ



УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяагийн ажлын албанаас хэрэгжүүлж буй **“Оюунлаг Хойд бүс”** хөтөлбөрийн хүрээнд **“Оюуны бэлэг–2026”** номын аяныг хоёр дахь жилдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэв.

Аяны зорилго нь алслагдсан сумдын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын унших боломжийг нэмэгдүүлэх, номын сангийн хүртээмжийг сайжруулах, хүүхэд, залуучуудын унших дадал, оюуны хөгжлийг дэмжихэд чиглэж байна.

Энэ хүрээнд “Нэг ахмад – Нэг ном” уриалгыг өрнүүлж, Орхон аймгийн Ахмадын хороо, Баян-Өндөр сумын багуудын Ахмадын зөвлөлүүд, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Жаргалант сумын ахмадын байгууллагууд идэвхтэй нэгдэн **1000 гаруй ном** хандивлав.

Цугларсан номыг Булган, Орхон, Хөвсгөл аймгийн сумдын ерөнхий боловсролын сургуулийн номын сан, дотуур байранд “Оюуны бэлэг” болгон хүргэж ажиллав.





Аяны хүрээнд сургагч багш Б.Зулчимэг, Г.Хонгорзул нартай хамтран ахмад настнуудад Ахмад настны тухай хууль, амьдралын чанар, эрүүл мэнд, сэтгэлзүй, өөрийгөө хамгаалах арга, бясалгал зэрэг сэдвээр сургалт, уулзалтыг зохион байгуулж, сурагчдад **“Эрэгээр инээ”** сэдэвт хувь хүний хөгжлийн сургалтыг зохион байгууллаа.



“BE ENGINEER” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ИРЭЭДҮЙН ИНЖЕНЕРҮҮДИЙГ ДЭМЖИЖ БАЙНА



УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяагийн ажлын алба, Хойд бүсийн хөгжлийн төв, Эрдэнэт цогцолбор их сургууль хамтран **“BE ENGINEER”** хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Уг хөтөлбөр нь **Хойд бүсийн хөгжилд шаардлагатай инженер, техникийн хүний нөөцийг урт хугацаанд бэлтгэх, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад инженерийн мэргэжлийн үнэ цэнэ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг таниулах, мэргэжлийн зөв чиг баримжаа олгох, үйлдвэрлэл–боловсролын уялдаа холбоог бэхжүүлэх** зорилготой юм.

Энэ хүрээнд Орхон, Булган аймагт **“Маргаашийг бүтээх мэргэжил”** уулзалт, ярилцлагыг зохион байгуулж, МУИС, ШУТИС, Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (GMIT), Шинэ Монгол технологийн их сургууль (NMIT), Эрдэнэт цогцолбор их сургуулийн эрдэмтэн, багш нар оролцон инженерийн боловсрол, элсэлтийн боломж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ирээдүйн карьерын хөгжлийн талаар ахлах ангийн сурагчдад мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллав.

Мөн хөтөлбөрийн хүрээнд их, дээд сургуулиудын төлөөлөл Орхон аймгийн удирдлагатай уулзаж, бүсийн хөгжлийн бодлого, үйлдвэрлэлийн өсөн нэмэгдэж буй хүний нөөцийн хэрэгцээг хангах, их сургууль–үйлдвэрлэл–орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, үйлдвэрлэлд суурилсан сургалт, судалгааны ажлыг хөгжүүлэх чиглэлээр санал солилцож, хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ.

“BE ENGINEER” хөтөлбөр нь инженерийн мэргэжлийг хүүхэд, залуучуудад сурталчлах, бүс нутагт шаардлагатай өндөр ур чадвартай инженер, техникийн боловсон хүчнийг бэлтгэх, улмаар Хойд бүсийн тогтвортой хөгжил, аж үйлдвэржилтийн хүний нөөцийн суурийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогын ач холбогдолтой санаачилга юм.






ХАНДИВ, ТУСЛАМЖ

Тойргийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын хэрэгцээ, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зорилтот дэмжлэгийг үзүүлж, боловсрол, нийгмийн хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хүүхэд залуучуудын хөгжил, спорт, ахмадын байгууллага, эмэгтэйчүүдийн манлайлал, иргэний оролцоог дэмжих чиглэлээр санхүүгийн болон эд материалын хандив, тусламжийг үзүүлэн ажиллалаа.





БОЛОВСРОЛ

- “Оюуны бэлэг” хөтөлбөрийн хүрээнд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сум, Булган аймгийн Орхон, Хангал, Сэлэнгэ сум, Хялганат тосгоны сургуулийн дотуур байрны номын санд 700 орчим ном хандивлаж, ахлах ангийн сурагчдад хандлага төлөвшүүлэх сургалт зохион байгуулав.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- Орхон аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, сургалтын төвийн үйл ажиллагааг дэмжиж ажлын хэрэгцээнд зориулан зөөврийн компьютер хандивлав.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, АХМАДЫН БАЙГУУЛЛАГА,

- Орхон аймгийн Баян-Өндөр сумын Ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжиж шагналын сан бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэв.

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖИЛ, МАНЛАЙЛАЛ

- Орхон аймаг дахь СДМЭХ-ны ээлжит чуулган, удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэв.
- Орхон аймаг дахь СДМЭХ-ны гишүүдийн уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэв.
- Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан SDWomen уулзалтыг дэмжив.

СОЁЛ, УРЛАГ

- “Мөрөнгийн хавар–2026” улсын хэмжээний нийтийн цэнгээнт бүжгийн тэмцээний зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэв.

Спорт, хүүхэд, залуучууд

- Хөвсгөл аймгийн Хатгал ЕБС-ийн тэшүүрийн багийг улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэв.
- Цагааннуур сумын Оюутны холбооны уламжлалт гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний зохион байгуулалтыг дэмжив.



ЗАЛУУ БАГШ НАРЫН ЭВ НЭГДЭЛ, ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГИЙГ ДЭМЖСЭН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭВ


Боловсролын салбарын залуу багш нарын мэргэжлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор Орхон аймгийн Залуу багш нарын холбоо, УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяагийн ажлын алба, Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуультай хамтран “Волейболын аварга шалгаруулах VIII тэмцээн”-ийг зохион байгуулж, ерөнхий боловсролын 14 сургуулийн залуу багш нарыг хамруулаа.

ИРГЭД, СОНГОГЧИДТОЙ ХИЙСЭН УУЛЗАЛТ

2026 оны хаврын чуулганы хугацаанд **19** хоног орон нутгийн томилолтоор ажиллаж, давхардсан тоогоор **4,000** гаруй иргэд, сонгогчидтой уулзалт хийж, санал хүсэлтийг нь сонсон, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.









- Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний үйлчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлээр иргэд, байгууллагын санал, хүсэлтийн дагуу Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төвд ажиллаж, 150 эмч, эмнэлгийн ажилтантай уулзалт хийв.
- УИХ-ын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүдийн хамт Орхон аймгийн боловсролын байгууллагууд болон “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн инженерийн хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж, 550 багш, ажилтан, оюутантай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.
- Орхон аймгийн МАН-ын хорооны гишүүдийн Сар шинийн золголт, Эх орончдын баярын хүралд оролцож, 1,500 намын гишүүнтэй уулзав.
- УИХ-ын гишүүн О.Саранчулууны хамт Орхон аймагт “Гэрээсээ гарцгаая” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 200 нийгмийн ажилтан, халамжийн салбарын алба хаагч, иргэнийг хамруулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт оролцов.
- Орхон аймагт “Хүртээмжтэй Намын Хороо” уулзалт-хэлэлцүүлгийг зохион байгуулж, 80 намын гишүүнийг хамруулав.





ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ТУРШЛАГА СОЛИЛЦОВ





Санхүүгийн зохицуулах хороо болон Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ээс хамтран зохион байгуулсан **“Жендэрт суурилсан хүртээмжтэй санхүүжилтийг хяналтын тогтолцоонд нэвтрүүлэх нь”** сэдэвт олон улсын хурлын нээлтэд оролцов.

Хуралд 40 гаруй улсын санхүүгийн зохицуулагч байгууллага, төв банкны бодлого боловсруулагчид оролцож, жендэрийн мэдрэмжтэй санхүүгийн бодлого, хяналтын тогтолцоо, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр туршлага солилцов.

Нээлтийн үеэр жендэрийн мэдрэмжтэй санхүүжилтийн бодлогыг хяналт, зохицуулалтын тогтолцоонд нэвтрүүлэх нь санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих чухал нөхцөл болохыг онцлон тэмдэглэж, энэ чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэхийн ач холбогдлыг илэрхийллээ.



“АЛТАЙ ДАМНАСАН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЯРИА ХЭЛЭЛЦЭЭ – 2026” ОЛОН УЛСЫН ФОРУМД ИЛТГЭЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭВ


Улсын Их Хурлын Тамгын газар, “Илүү гэрэлт ирээдүйн төлөө” сан, Стэнфордын их сургууль, Эва эмэгтэйчүүдийн их сургууль хамтран зохион байгуулсан **“Алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ – 2026”** олон улсын форумд оролцож, “**Эмэгтэйчүүдийн манлайлал, чадавхжуулалт”** сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.



Илтгэлдээ эмэгтэйчүүдийн манлайлал нь







улс төр, эдийн засаг, нийгмийн институцийн дэмжлэгтэй салшгүй холбоотой хөгжлийн бодлогын асуудал болохыг онцолж, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцоо, тэгш боломжийг хангах бодлого, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн ач холбогдлын талаар байр сууриа илэрхийллээ.







ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ, ЭРЧИМ ХҮЧНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ПАНЕЛИСТААР ОРОЛЦОВ

“Эрчим хүчний болон газрын тосны бүтээгдэхүүний хараат байдлыг бууруулах, эрчим хүчний шилжилтийн хүрээнд олон талт түншлэлийг бэхжүүлэх нь” сэдэвт үндэсний хэлэлцүүлэгт панелистаар оролцож, **“Цахилгаан тээврийн хэрэгсэл ба түүний дэд бүтэц, чанар, стандарт, санхүүжилтийн бодлого”** сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.



Хэлэлцүүлгийн хүрээнд эрчим хүчний шилжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, цахилгаан тээврийн хэрэгслийн дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүлж, гарсан санал, зөвлөмжийг хууль тогтоох болон бодлогын түвшинд тусган ажиллах байр суурийг илэрхийлэв.







ЕВРОПЫН ХОЛБООТОЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ, ЧАДАВХЖУУЛАЛТЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛНЭ






Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд **Ина Марчюлёните** болон холбогдох албаны төлөөлөлтэй уулзаж, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, манлайллыг дэмжих, чадавхжуулах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцов. Уулзалтаар СДМЭХ-ны дэргэдэх Эмэгтэйчүүдийн академийн үйл ажиллагааг танилцуулж, Литва улсын эмэгтэй парламентчидтай туршлага солилцох, сургалт, цахим уулзалтыг хамтран зохион байгуулах, мөн Европын Холбоо, Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хамтын ажиллагааны хүрээнд Хойд бүсэд сэргээгдэх эрчим хүч, орон сууц, хотын дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх боломжийн талаар санал солилцов.

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКТАЙ ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАВ





Улсын Их Хурлын холбогдох ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд Азийн хөгжлийн банкны олон улсын зөвлөх **Кристофер Рашельтай** уулзаж, төрийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах эрх зүйн шинэчлэл, төр–хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоо, олон улсын сайн туршлагыг хууль тогтоомжид тусгах асуудлаар санал солилцов. Уулзалтын үр дүнд олон улсын байгууллагаас дэвшүүлсэн зөвлөмж, санал, дүгнэлтийг **“Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай”** хуулийн төсөл болон холбогдох эрх зүйн зохицуулалтад тусган боловсруулах чиглэлээр хамтран ажиллаж, төрийн өмчит компанийн засаглалын шинэчлэлийг олон улсын жишигт нийцүүлэх, институцийн чадавхыг бэхжүүлэх, бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг өргөжүүлэв.



ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНКТАЙ ТӨРИЙН ӨМЧИЙН ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАВ





Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны суурин төлөөлөгч **Жахан Шамсиев** болон холбогдох албаны төлөөлөлтэй уулзаж, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн **“Нийтийн өмчийн тухай хууль” болон “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль”**-ийн төслүүдийн боловсруулалт, уялдаа холбоо, цаашдын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Уулзалтад УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн дэд ахлагч П.Сайнзориг, УИХ-ын гишүүн О.Номинчимэг нарын хамт оролцож, хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах хүрээнд олон улсын сайн туршлага, компанийн засаглалын зарчим, төрийн өмчийн шинэчлэлийн аргачлалыг хууль тогтоомжид тусгах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлыг танилцуулж, мэргэжлийн болон техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцов.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зүгээс төрийн өмчит компанийн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх чиглэлээр олон улсын зөвлөхүүдийн оролцоог хангах, техникийн туслалцаа үзүүлэх, туршилтын оношилгоо хийх боломжтойгоо илэрхийлсэн. Уулзалтын үеэр өгсөн зөвлөмж, санал, дүгнэлтийг хуулийн төслийн боловсруулалт болон хэрэгжилтийн механизмд тусган ажилласнаар төрийн өмчийн засаглалын шинэчлэлийг олон улсын сайн туршлага, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын компанийн засаглалын зарчимд нийцүүлэн хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааг бэхжүүлэв.



МОНГОЛ АРДЫН НАМЫН 105 ЖИЛИЙН ОЙ, “ЭХ ОРОНЧДЫН ӨДӨР”-ИЙН ХҮРЭЭНД НАМЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ГИШҮҮДИЙН ОРОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОВ



Монгол Ардын Нам үүсэн байгуулагдсаны 105 жилийн ой, “Эх орончдын өдөр”-ийг тохиолдуулан Орхон аймагт зохион байгуулсан арга хэмжээнд оролцож, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд одон, медалиар шагнагдсан салбар салбарын шилдэг ажилтан, ахмадуудад шагналыг гардуулан өгч, намд шинээр элссэн гишүүдэд намын батлахыг нь гардууллаа. Мөн намын үзэл баримтлал, үнэт зүйл, бодлого, үйл ажиллагааг иргэд, гишүүдэд сурталчлан таниулах, намын анхан шатны байгууллагын үйл ажиллагаа, гишүүдийн оролцоог бэхжүүлэхэд чиглэсэн улс төр, олон нийтийн арга хэмжээнд оролцож ажиллав.



“ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ДӨРВӨН ЗАМ: ДӨРВӨН ЧӨЛӨӨЛӨЛТ” БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР ИРГЭДИЙН САНАЛ, ОРОЛЦООГ ХАНГАЖ АЖИЛЛАВ



Монгол Ардын Намын дарга, Улсын Их Хурлын дарга Н.Учралын хойд бүсийн орон нутгийн томилолтын ажлын бүрэлдэхүүнд ажиллаж, Булган, Орхон аймгийн иргэдтэй “Эрх чөлөөний дөрвөн зам: Дөрвөн чөлөөлөлт” бодлогын хүрээнд нээлттэй уулзалт, хэлэлцүүлэг оролцов. Уулзалтаар эдийн засаг, эрх зүй, эрчим хүчний бие даасан байдал, авлигын эсрэг шинэчлэлийн чиглэлээр хэрэгжүүлж буй хууль тогтоомж, бодлогын арга хэмжээний хэрэгжилтийг танилцуулж, иргэдийн санал, байр суурийг сонсон бодлого боловсруулах үйл ажиллагаанд тусгах зорилгоор нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэв.

ХҮРТЭЭМЖТЭЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮНИЙ ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАВ



УИХ-ын гишүүн О.Саранчулууны хамт Орхон аймагт “Гэрээсээ гарцгаая” нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн ажилтан, халамжийн байгууллагын албан хаагчдад зориулсан хүний эрх, мөнгөн бус үйлчилгээний тогтолцоо, аутизмын талаарх ойлголт, хүүхдийн хөгжлийн дэмжлэгийн чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг зохион байгуулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэв. Мөн тус арга хэмжээний хүрээнд Монгол Ардын Намын гишүүд, дэмжигчидтэй уулзаж, “Гишүүн төвтэй нам” бодлогын хүрээнд боловсруулсан “Хүртээмжтэй намын хороо” гарын авлагыг танилцууллаа.





НАМЫН БОДЛОГО, ШИНЭЧЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ГИШҮҮДТЭЙ САНАЛ СОЛИЛЦОВ



Баянгол, Сүхбаатар дүүргийн Монгол Ардын Намын гишүүд, дэмжигчдэд, Улсын Их Хурал, Засгийн газар болон намын бодлого, шийдвэрийн хэрэгжилт, ур дүнг танилцуулах уулзалтад оролцож, иргэдийн санал, байр суурийг сонсон цаашдын бодлогын хэрэгжилтэд тусгах чиглэлээр нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэв.







СОЦИАЛ ДЕМОКРАТ
МОНГОЛЫН
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБОО



СОЦИАЛ ДЕМОКРАТ МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР СОНГОГДОЖ, “WOMEN” БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ЭХЛҮҮЛЭВ



Миний бие МАН-ын дэргэдэх СДМЭХ-ны Ерөнхийлөгчөөр сонгогдож эмэгтэйчүүдийн улс төр, нийгэм, эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх, байгууллагын засаглал, манлайлал, чадавхыг бэхжүүлэх зорилготой **WOMEN** бодлогыг дэвшүүлэн үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхлэв.

WOMEN бодлого нь **WELLBEING, OPPORTUNITIES, MOTHERHOOD, EMPLOYMENT, NATIONAL VALUES** гэсэн таван тулгуур чиглэлд суурилж, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол, манлайлал, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, үндэсний үнэт зүйлсийг дэмжих цогц бодлогыг үндэсний болон орон нутгийн түвшинд үе шаттайгаар хэрэгжүүлэх институцийн шинэчлэлийн эхлэлийг тавив.









WOMEN WELLBEING

“ЭРҮҮЛ ЭМЭГТЭЙ - ХҮЧИРХЭГ МОНГОЛ”



- Эмэгтэйчүүдийн эрт оношилгоо
- Хангайн бүсийн оношилгооны төвд эрт оношилгоо хөтөлбөр
- Эрдэнэт хотын хавдар судлалын төв дээр эрт оношилгоо хөтөлбөр
- Спорт өдөрлөг

“ЭРҮҮЛ МОНГОЛ ЭЭЖ” ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ

БИЕИЙН ЭРҮҮЛ МЭНД, СЭТГЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНД, ОЮУНЫ ЭРҮҮЛ МЭНД


WOMEN бодлогын Wellbieng чиглэлийн хүрээнд хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол ээж” хөтөлбөрийн дагуу Бүгд Найрамдах Солонгос Улсын “АСАН эмнэлэг”-ийн 30 гаруй эмч, мэргэжилтнээс бүрдсэн багийг Орхон аймагт ажиллуулж, Хойд бүсийн Хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төвд уушгины эмгэг, дотор, чих, хамар, хоолой, хөхний эхо, нөхөн сэргээх болон пластик мэс заслын чиглэлээр төрөлжсөн үзлэг, оношилгоо, мэргэжлийн зөвлөгөөг зохион байгууллаа. Үзлэг, оношилгоонд нийт 1,500 иргэн хамрагдав.

Энэхүү арга хэмжээ нь эх, эмэгтэйчүүд болон иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төрөлжсөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг орон нутагт хүргэх, олон улсын эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, туршлагыг нутагшуулах, иргэдийг оршин суугаа газартаа чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг өргөжүүлэхэд чиглэж байна.











“ОЮУНЛАГ НҮҮДЭЛ” СОНИРХЛЫН КЛУБЫГ БАЙГУУЛЖ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОЮУНЫ МАНЛАЙЛЛЫГ ДЭМЖИВ



СДМЭХ-ны дэргэдэх 100 сонирхлын клуб байгуулах санаачилгын хүрээнд Монголын шатрын холбоо, IQ EQ Академитай хамтран эмэгтэйчүүдийн оюуны хөгжил, стратегийн сэтгэлгээ, манлайллыг дэмжих зорилгоор “Оюунлаг нүүдэл” сонирхлын клубыг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэв. Клубын хүрээнд эмэгтэйчүүдийн “Блиц шатрын тэмцээн–2026”-г зохион байгуулж, 60 гаруй шатарчин, үүнээс спортын мастер болон түүнээс дээш зэрэглэлтэй 20 гаруй тамирчин оролцсон нь эмэгтэйчүүдийн оюуны спортын оролцоог нэмэгдүүлэх, стратегийн сэтгэлгээ, манлайллыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын ач холбогдолтой арга хэмжээ болов.

WOMEN OPPORTUNITIES

“ТЭГШ БОЛОМЖ-ТОГТВОРТОЙ ИРЭЭДҮЙ”



- Эмэгтэйчүүдийн академи
- Бүх боломж хүн бүрт тэгш боломж

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АКАДЕМИ БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА.



WOMEN бодлогын Opportunities чиглэлийн хүрээнд эмэгтэйчүүдийн улс төр, нийгэм, эдийн засгийн манлайллыг тогтвортой хөгжүүлэх, шийдвэр гаргах түвшний эмэгтэй манлайлагчдыг бэлтгэх, судалгаа, сургалт, чадавхжуулалтад суурилсан үндэсний тогтолцоог бүрдүүлэх зорилгоор СДМЭХ-ны дэргэд “Эмэгтэйчүүдийн академи” байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Энэ хүрээнд академийн үзэл баримтлал, зорилго, бүтэц, сургалтын тогтолцоо, үйл ажиллагааны загварыг боловсруулах суурь судалгааг гүйцэтгэж, олон улсын сайн туршлагад тулгуурласан хөгжлийн загварыг тодорхойлон ажиллаж байна. Цаашид Япон, БНСУ зэрэг орны эмэгтэйчүүдийн манлайлал, улс төрийн боловсролын академийн үйл ажиллагааны харьцуулсан судалгааг нэгтгэн боловсруулж, сургалтын хөтөлбөр, институцийн хөгжлийн төлөвлөгөө, хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэн хэрэгжүүлнэ.

Энэхүү академи нь эмэгтэйчүүдийн манлайлал, улс төрийн боловсрол, төрийн удирдлага, бодлого боловсруулах чадавх, олон улсын хамтын ажиллагаа, судалгаанд суурилсан сургалтын нэгдсэн платформ болж хөгжих стратегийн зорилготой юм.

“SDW СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ЭМЭГТЭЙ МАНЛАЙЛАГЧДЫН УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭВ

Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо /СДМЭХ/-ноос гишүүдийн улс төрийн боловсрол, хувь хүний хөгжил, манлайллын ур чадварыг нэмэгдүүлэх, орон нутаг болон дүүргийн түвшинд сурган чиглүүлэх чадамжтай эмэгтэй манлайлагчдыг бэлтгэх зорилгоор “SDW сургагч багш бэлтгэх сургалт”-ыг 2026 оны тавдугаар сарын 18–23-ны өдрүүдэд зохион байгууллаа.



Түс сургалтад 21 аймаг, 9 дүүргийн



төлөөллөөс шалгарсан 30 оролцогч хамрагдаж, Улс төрийн манлайллын академийн мэргэшсэн багш нарын удирдлага дор илтгэх ур чадвар, хувь хүний хөгжил, коучинг арга зүй, манлайлал, багийн ажиллагаа, мэдээлэл боловсруулах чадвар, хиймэл оюун ухаан ашиглан контент бүтээх аргачлал зэрэг чиглэлээр мэдлэг, ур чадвараа дээшлүүлэв.

Энэхүү сургалт нь технологийн хурдацтай хөгжил, хиймэл оюун ухааны хэрэглээ нийгэм, эдийн засаг, улс төрийн орчинд нөлөөлж буй шинэ нөхцөлд эмэгтэйчүүдийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, намын анхан болон дунд шатанд ажиллах манлайлагчдыг бэлтгэхэд чиглэсэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Сургалтын үр дүнд бэлтгэгдсэн 30 сургагч багш цаашид өөрийн аймаг, дүүрэгтээ 10 хүртэлх сургагч багш бэлтгэх замаар үндэсний хэмжээнд 300 орчим сургагч багшийн сүлжээ бий болгох зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.







MENTOR-105 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭВ

MENTOR-105 үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, зургаан бүс болон нийслэлд нийт 105 ментор, 105 ментийг бэлтгэх тогтолцоог эхлүүлэн, “She for She” үзэл баримтлалд тулгуурласан манлайллын үе залгамжийг бий болгох үндэс суурийг тавилаа.

Хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан “Менти” сонирхлын клуб-ийн үйл ажиллагааг эхлүүлж, залуу эмэгтэйчүүдийг туршлагатай манлайлагчидтай холбон хувь хүний хөгжил, манлайллын ур чадвар, улс төрийн боловсролыг дэмжих тогтолцоог бий болгож, тогтмол уулзалт, сургалт, туршлага солилцооны арга хэмжээг зохион байгуулав.



WOMEN MOTHERHOOD



“ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ-
УЛС ОРНЫ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА”

ЭХ, ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭВ



WOMEN бодлогын **Motherhood** чиглэлийн хүрээнд “Эхийн алдар” I, II зэргийн одон гардан авч буй эхчүүд болон тэдний гэр бүлд зориулсан **үйлчилгээний асрыг** ажиллуулж, бага насны хүүхэдтэй эхчүүдэд хүүхэд харах, эх, хүүхдийн амрах орчин, эрүүл мэндийн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл, гэр бүлийн үйлчилгээ зэрэг цогц дэмжлэгийг нэг дор үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэв. Энэхүү арга хэмжээ нь эхчүүдийн нийгмийн оролцоог дэмжих, гэр бүлд ээлтэй орчныг төлөвшүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх бодлогын хэрэгжилтийг хангахад чиглэсэн ач холбогдолтой.











Эх, гэр бүл, хүүхдийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр **“Алдарт эхийн одонг ээжүүдийн хүндэтгэлийн арга хэмжээ”, “Хамтдаа гэрэлтэе”** зэрэг Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан арга хэмжээнүүдэд оролцож, эх хүний хөдөлмөр, асрахуйн эдийн засаг, гэр бүлийн үнэ цэнийг бодлогын түвшинд дэмжих байр суурийг илэрхийллээ.

“Есөн эрдэнэ–2026” шилдэг эмэгтэйчүүдийг алдаршуулах ёслол, орон нутгийн эмэгтэйчүүдийн уулзалтууд, баярын арга хэмжээнүүдэд оролцож, улс орон, нийгэм, гэр бүлийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан эмэгтэйчүүдийн хөдөлмөр, манлайллыг бодлогын түвшинд үнэлэх, олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг өргөжүүлэв.

WOMEN ENTREPRENEUR



- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бүсийн зөвлөгөөн
- 21 аймаг Малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт

“ШИНЭ САНАЛ-БҮТЭЭЛЧ ЭМЭГТЭЙ”

ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭВ



WOMEN бодлогын Entrepreneur чиглэлийн хүрээндэмэгтэйбизнесэрхлэгчдийнманлайлал, өрсөлдөх чадвар, эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор **“Бүтээж, манлайлж, хөгжүүлнэ”** арга хэмжээг Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, 300 гаруй эмэгтэй бизнес эрхлэгчийг нэгтгэн оролцууллаа. Энэхүү арга хэмжээ нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлах, зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох, бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, эмэгтэйчүүдийн энтрепренёршипийг бодлогын түвшинд дэмжихэд чиглэсэн ач холбогдолтой арга хэмжээ болов.

Мөн Булган, Ховд болон бусад орон нутагт зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлгийн үеэр эмэгтэй бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, бичил болон гарааны бизнесийг дэмжих бодлогын хэрэгцээ, орон нутгийн онцлогт тулгуурласан бизнесийн боломжийг нэмэгдүүлэх асуудлаар санал солилцож, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдсан эмэгтэйчүүдийн энтрепренёршипийг дэмжих чиглэлүүдийг тодорхойлон ажиллав.







WOMEN NATIONAL VALUES



- Мөрдөстэй эмэгтэйчүүд- Эх орны түшиг зөвлөгөөн
- Монгол хэл, бичгийн бүсчилсэн зөвлөгөөн
- Монгол хэл, бичгийн үндэсний зөвлөгөөн- Төрийн ордон

“ЭХ ОРОНЧ СЭТГЭЛГЭЭ-ТУСГААР ТОГТНОЛЫН БАТАЛГАА”

Эмэгтэйчүүдийн эв нэгдэл, үндэсний үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх хүрээнд

МОНГОЛ ХЭЛ, ҮНДЭСНИЙ БИЧГИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ӨРНҮҮЛЭВ





WOMEN бодлогын **“N – National Values”** чиглэлийн хүрээнд үндэсний хэл, бичиг, өв соёлыг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор **Монгол хэл, бичгийн багш нарын анхдугаар чуулганыг** зохион байгуулж, монгол хэл, үндэсний бичгийн сургалтын чанар, хэрэглээ, өвлүүлэн уламжлуулах бодлогын асуудлыг хэлэлцэв. Чуулганд нийслэл болон 21 аймгийг төлөөлсөн монгол хэл, уран зохиолын багш нар оролцож, үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хүүхэд, залуу үеийн эх хэлний боловсролыг бэхжүүлэх, багш нарын мэргэжлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцож, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлов.



ҮНДЭСНИЙ ӨВ СОЁЛ, ҮНДЭСНИЙ БАХАРХЛЫГ ӨВЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДАД ЧИГЛЭСЭН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭВ



Хүүхэд, өсвөр үеийнхэнд үндэсний өв, уламжлал, үнэт зүйлсийг өвлүүлэн төлөвшүүлэх зорилгоор үндэсний бөхийн ёс заншил, дэг жаяг, соёлыг сурталчлах арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд үндэсний бөхийн барилдааны дэг жаяг, ёс заншил, соёлын үнэ цэнийг сурагчдад танилцуулж, хүчит бөхчүүдийн барилдааны үзүүлбэрээр дамжуулан Монгол үндэсний өв уламжлал, эх оронч үзэл, бахархлыг төлөвшүүлэх, соёлын биет бус өвийг хүүхэд, залуу үед өвлүүлэн уламжлуулахад чиглэсэн бодлогын ач холбогдолтой үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

365 – ЭВДРЭЭГҮЙ ИРЭЭДҮЙГ БҮТЭЭЕ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Цагдаагийн ерөнхий газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, “И-Монгол академи” УТҮГ-аас хамтран зохион байгуулсан “365 – Эвдрээгүй ирээдүйг бүтээе” зөвлөгөөнд панелистаар оролцож, цахим орчин дахь хүүхэд хамгаалал, эцэг эхийн үүрэг, оролцоо, төрийн бодлогын шинэчлэлийн талаар байр сууриа илэрхийллээ.

Хэлэлцүүлгийн үеэр цахим хэрэглээ нэмэгдэхийн хэрээр хүүхдийн цахим орчин дахь дээрэлхэлт, доромжлол, сөрөг нөлөөлөл нэмэгдэж буй нь зөвхөн гэр бүлийн хүмүүжил, хувь хүний асуудал бус, төрөөс бодлогын түвшинд анхаарах шаардлагатай нийгмийн эрсдэл болохыг онцлон тэмдэглэв.

Мөн эцэг эхийн оролцоог сайн дурын хандлагаас бодлогоор дэмжсэн тогтолцоонд шилжүүлэх, эцэг эхийн боловсролыг системтэй хөгжүүлэх, сургууль, гэр бүлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүүхдийн цахим орчны аюулгүй байдлыг хангах эрх зүйн болон институцийн орчныг боловсронгуй болгох, зөвлөгөө, дэмжлэгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын шинэчлэл хийх шаардлагатай талаарх саналыг дэвшүүлэв.

Түүнчлэн хүүхдийн цахим орчныг аюулгүй байдлыг хангах асуудал нь гэр бүл, боловсролын байгууллага, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын хариуцлагад тулгуурлах ёстойг онцолж, хүүхэд хамгааллын бодлого, хууль эрх зүйн зохицуулалтыг уялдаа холбоотойгоор боловсронгуй болгох чиглэлээр хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг онцлон дурдав.







ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА
ГАДААД ХАРИЛЦААГ ӨРГӨЖҮҮЛЭВ



Хаврын чуулганы хугацаанд нийт 6 удаагийн гадаад албан томилолтоор Япон Улс (2), Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллаж, парламент хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал, оролцоог дэмжих, боловсрол, шинжлэх ухаан, бүсчилсэн хөгжил, дижитал шилжилт, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн уулзалт, хэлэлцээ, албан арга хэмжээнд оролцлоо.

Албан томилолтын хүрээнд Япон, БНСУ, Польш, Герман улсын парламент, төрийн байгууллага, улс төрийн намууд, их, дээд сургууль, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааны асуудлаар санал солилцож, парламентын засаглал, эмэгтэйчүүдийн манлайлал, боловсрол, инновац, уул уурхай, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, бүсчилсэн хөгжлийн чиглэлээр туршлага судаллаа.


Мөн Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо болон Бүх Хятадын Эмэгтэйчүүдийн Холбоо хоорондын хамтын ажиллагааны Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, Монгол, Японы парламентын гишүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хойд бүсийн аймгуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх, БНСУ-ын Корё их сургуультай боловсрол, судалгаа, хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийг байгуулан хэрэгжүүлэх үндсийг бүрдүүлэв.

Эдгээр гадаад харилцааны үйл ажиллагаа нь парламентын дипломат харилцааг бэхжүүлэх, Монгол Улсын хөгжлийн бодлогод олон улсын сайн туршлагыг нутагшуулах, боловсрол, эмэгтэйчүүдийн манлайлал, бүсчилсэн хөгжил, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодит үр дүнтэй ажил болов.



БНХАУ – БЭЭЖИН 2026.03.22-24


Монгол Ардын Намын дарга, УИХ-ын дарга Н.Учралын БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд ажиллаж, Хятадын Коммунист Намын Төв хорооны Гадаад харилцааны газрын дарга **Лю Хайшинтай** хийсэн уулзалтад оролцов. Уулзалтаар хоёр намын хамтын ажиллагаа, нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, хамтын ажиллагааны шинэ боломжуудын талаар санал солилцов.



БНХАУ – БЭЭЖИН

2026.03.23

Хятадын Коммунист Намын Улс төрийн товчооны Байнгын хорооны гишүүн, Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга Жао Лөжитэй хийсэн албан уулзалтад оролцож, парламент хоорондын хамтын ажиллагаа, худалдаа, эдийн засаг, дэд бүтэц, хил дамнасан төмөр замын холболтыг эрчимжүүлэх асуудлаар хэлэлцэв.







БНХАУ – БЭЭЖИН

2026.03.24

Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо (СДМЭХ) болон Бүх Хятадын Эмэгтэйчүүдийн Холбоо хамтын ажиллагааны Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хоёр байгууллагын урт хугацааны түншлэлийн эрх зүйн үндсийг бүрдүүлэв. Санамж бичгийн хүрээнд эмэгтэйчүүдийн манлайлал, улс төрийн оролцоо, бизнес эрхлэлт, ногоон хөгжил, эх хүүхдийн эрүүл мэнд, олон улсын хамтын ажиллагааны чиглэлээр хамтарсан төсөл, сургалт, туршлага солилцоог хэрэгжүүлэхээр тохиролцов.



ХБНГУ – БЕРЛИН

2026.04.20

Монгол Ардын Намын Ерөнхий нарийн бичгийн дарга Я.Содбаатар тэргүүтэй төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Германы Социал Демократ Намын Ерөнхий нарийн бичгийн дарга Тим Клюссэндорфтой хийсэн нам хоорондын хэлэлцээнд оролцож, социал демократ үзэл баримтлал, намын шинэчлэл, олон улсын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.







ХБНГУ – БЕРЛИН

2026.04.21

ХБНГУ-ын Канцлер асан, Бундестагийн гишүүн Олаф Шольцтой хийсэн уулзалтад оролцож, Монгол–Германы хамтын ажиллагаа, ногоон шилжилт, сэргээгдэх эрчим хүч, дэлхийн эрчим хүчний зах зээлийн нөхцөл байдлын талаар санал солилцов.







ХБНГУ – БЕРЛИН

2026.04.21

Фридрих-Эбертийн сангийн Ерөнхийлөгч Мартин Шүльц болон удирдлагуудтай уулзаж, социал демократ үзэл баримтлал, улс төрийн боловсрол, институцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хэлэлцэв.





ХБНГУ – БЕРЛИН

2026.04.21

Германы Социал Демократ Намын Эмэгтэйчүүдийн Холбооны дарга, Бундестагийн гишүүн Кармэн Вэггэ-тэй албан уулзалт хийж, хоёр байгууллагын хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, манлайлал, улс төрийн боловсрол, чадавхжуулах сургалтын чиглэлээр урт хугацааны хамтын ажиллагааг эхлүүлэхээр санал нэгдэв.



ХБНГУ – БЕРЛИН

2026.04.22

Бундестагийн гишүүн Др.Ролф Мютцэнихтэй уулзаж, Монгол–Германы парламент хоорондын хамтын ажиллагаа, байнгын хороод болон парламентын бүлгүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцов.



ХБНГУ – БЕРЛИН

2026.04.22

Германы Социал Демократ Намын төлөөлөгчидтэй нам хоорондын хэлэлцээ хийж, социал демократ түншлэл, олон улсын хамтын ажиллагаа, гадаад бодлого, аюулгүй байдал, залуучуудын оролцоог дэмжих асуудлаар санал солилцов.







ХБНГУ – БЕРЛИН

2026.04.22

Бундестагийн гишүүн, Германы Социал Демократ Намын Байгаль орчин, уур амьсгалын хамгаалал хариуцсан илтгэгч Якоб Бланкенбургтай уулзаж, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх хамтын ажиллагаа болон Монгол Улсад зохион байгуулагдах НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын оролцогч талуудын XVII бага хурлын талаар мэдээлэл солилцов.







ЯПОН – ТОКИО





Япон Улсын парламентын эмэгтэй гишүүд болон Либерал Ардчилсан Намын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн удирдлагуудтай албан уулзалтууд зохион байгуулж, эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлал, шийдвэр гаргах түвшний оролцоо, сонгуулийн тогтолцоо, жендэрийн квот, парламентын хамтын ажиллагааны талаар туршлага солилцов.





Энэ хүрээнд:

Төлөөлөгчдийн танхимын гишүүн Сүзүки Такако, Зөвлөхүүдийн танхимын гишүүн Ивамото Мана нартай хоёр талын уулзалт хийж, Монгол, Японы эмэгтэйчүүдийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, СДМЭХ-ны “Эмэгтэйчүүдийн академи” санаачилгын хүрээнд хамтран ажиллах, Японы парламентын эмэгтэй гишүүдийг 2026 онд Улаанбаатар хотноо зохион байгуулах Олон улсын парламентч эмэгтэйчүүдийн чуулганд оролцохыг урив.





Мөн Монгол Улсаас Япон Улсад суугаа Элчин сайдын яамны санаачилгаар анх удаа зохион байгуулагдсан Монгол, Японы парламентын эмэгтэй гишүүдийн нетворкинг уулзалтд оролцож, Монгол Улсын жендэрийн бодлогын шинэчлэл, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн шинэчлэлийн талаар танилцуулан, хоёр улсын парламентын эмэгтэй гишүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар санал солилцов.



БНСУ – СӨУЛ

2026.06.05–06




СДМЭХ-ны төлөөлөгчдийг ахлан Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллаж, Үндэсний Ассамблейн Эмэгтэйчүүдийн хорооны дарга **Со Мён Уг,** Үндэсний Ассамблейн гишүүн **Ом Тэ Ён,** орон нутгийн удирдлага, их сургууль болон олон улсын байгууллагуудтай албан уулзалтууд хийв.

Айлчлалын хүрээнд:

- эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх,
- KOICA-гийн дэмжлэгтэй хэрэгжсэн төслийн дараагийн үе шатыг эхлүүлэх,
- орон нутгийн эмэгтэй манлайлагчдыг чадавхжуулах,
- хиймэл оюун ухаан, дижитал шилжилтийн чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлыг хэлэлцэв.

Мөн БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн хүүхдүүдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах асуудлыг парламентын түвшинд хөндөн тавьж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахаар тохиролцов.





Корё Их Сургуультай боловсрол, хууль эрх зүй, манлайллын чиглэлээр хамтран ажиллах **санамж бичиг** байгуулав.



Global Management Support Association (GMSA)-тай байгууллагын засаглал, хиймэл оюун ухаан, дижитал шилжилт, эмэгтэйчүүдийн манлайллын чиглэлээр хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа.





БҮХ ХЯТАДЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ИХ СУРГУУЛЬТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭВ

БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шэнь Миньжуаньтай уулзаж, Бээжин хотноо байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийг эхлүүлэх асуудлаар санал солилцов. Энэ хүрээнд СДМЭХ-ны гишүүдийг БНХАУ-ын ногоон хөгжил, сайн засаглал, сэргээгдэх эрчим хүч, эмэгтэйчүүдийн манлайллын чиглэлээр сургалт, туршлага судлах хөтөлбөрүүдэд хамруулах, Бүх Хятадын Эмэгтэйчүүдийн Их сургуультай хамтын ажиллагааг эхлүүлэхээр тохиролцов.



БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫН ЭЛЧИН САЙД АТУЛ МАЛХАРИ ГОТСУРВЕТАЙ УУЛЗАЖ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ АСУУДЛААР САНАЛ СОЛИЛЦОВ.



Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Атул Малхари Готсурветай уулзаж, эмэгтэйчүүдийн хөгжил, эдийн засгийн оролцоо, орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцов. Уулзалтаар Энэтхэгийн Засгийн газрын төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр, төрийн бус байгууллагын салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх боломж, эмэгтэйчүүдийн хоршоолол, бичил бизнесийг дэмжих, малчин эмэгтэйчүүдийн сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх хамтарсан төсөл хэрэгжүүлэх боломжийг хэлэлцэв. Түүнчлэн эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, соёлын хамтын ажиллагааны чиглэлээр хамтарсан арга хэмжээ зохион байгуулах асуудлаар санал нэгдэж, хоёр талын хамтын ажиллагааг бодит агуулгаар өргөжүүлэхээр тохиролцов.

СОЦИАЛ ДЕМОКРАТ МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭВ.

СДМЭХ-ны ээлжит бус Их хурлаар холбооны шинэ хөгжлийн бодлого болох WOMEN бодлогыг баталгаажуулж, шинэ бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог бүрдүүлэн, Удирдах зөвлөлийн анхдугаар хурлаар хэрэгжилтийн төлөвлөгөөг батлав. Ингэснээр байгууллагын үйл ажиллагааг бодлого, үр дүн, ил тод засаглалд суурилсан тогтолцоонд шилжүүлэх үндэс бүрдэж, үндэсний хэмжээнд салбар холбоодын шинэчлэлийг эхлүүлэх нөхцөл бүрдэв.





СОЦИАЛ ДЕМОКРАТ МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН АНХДУГААР ХУРАЛ БОЛЛОО



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СДМЭХ-НЫ “ЭМЭГТЭЙЧҮҮД ОЛУУЛАА” УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



СДМЭХ-НЫ УДИРДЛАГУУД БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ АЖИЛЛАЛАА



ОРХОН АЙМГИЙН СДМЭХ-НЫ ЭЭЛЖИТ ЧУУЛГАН БОЛОН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

СОЦИАЛ ДЕМОКРАТ МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ БҮС ХАРИУЦСАН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН УУЛЗАЛТ БОЛЛОО



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СДМЭХ-НЫ ЭЭЛЖИТ ЧУУЛГАН БОЛОН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО



СДМЭХ-НЫ УДИРДЛАГУУД БУЛГАН АЙМАГТ АЖИЛЛАЛАА



СОЦИАЛ ДЕМОКРАТ МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ УДИРДЛАГУУД ХОВД АЙМАГТ АЖИЛЛАЛАА



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Доржсүрэнгийн **ҮҮРИЙНТУЯА**

СОЦИАЛ ДЕМОКРАТ МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮР ДҮНГИЙН ДАШБОРД

5,000 +
НИЙТ ХАМРАГДСАН ИРГЭД, ГИШҮҮД

2,200 +
ОРОН НУТГИЙН ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН ОРОЛЦОГЧИД

700 +
БАГШ, СУДЛААЧДЫН ОРОЛЦОО

300
ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН ЖДҮ (SMEs)

300 +
ТӨРИЙН ОРДОНД ОДОН ГАРДАН АВСАН ЭЭЖҮҮД

185
25 АЖЛЫН ХЭСЭГТ



СДМЭХ-НЫ ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАР ХОЛБООНЫ 8 ДУГААР ЧУУЛГАН БОЛЛОО



МОНГОЛ АРДЫН НАМЫН ДЭРГЭДЭХ СДМЭХ-НЫ ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН САЛБАР ХОЛБООНЫ “УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН” БОЛЛОО



“ЭМЭГТЭЙЧҮҮД ОЛУУЛАА” УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨНӨӨР ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛАЛ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ОНЦОЛЛОО



“ОРОЛЦООНООС МАНЛАЙЛАЛ РУУ” ӨГЛӨӨНИЙ УУЛЗАЛТ СОЦИАЛ ДЕМОКРАТ МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ БАГА ХУРЛЫН ГИШҮҮДИЙН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

СДМЭХ-НЫ СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ХОЛБООНЫ ЧУУЛГАН БОЛЛОО



СОЦИАЛ ДЕМОКРАТ МОНГОЛЫН ЭМЭГТЭЙҮҮДИЙН ХОЛБООНЫ ХЭНТИЙ АЙМГИЙН САЛБАР ХОЛБООНЫ УДИРДЛАГА, ТЭРГҮҮЛЭГЧИД, 18 СУМЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАР ОРОЛЦСОН “ФОКУС-26” УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА





СДМЭХ-НЫ БАЯНГОЛ ДҮҮРГИЙН САЛБАР ХОЛБОО “ЭМЭГТЭЙЧҮҮД ОЛУУЛАА” УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛЛАА



СДМЭХ-НЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖСЭН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА



СДМЭХ 1000 мод тарьж, 1000 мод усаллаа.

СДМЭХ-ны байранд Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан болон холбогдох газрын удирдлагуудтай уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар хүүхэд хамгаалал, гэр бүлийн хөгжил, хүний хөгжлийн бодлого, хүүхдийн зуслан, эцэг эхийн боловсрол, эх хэл соёл, цахим орчны эрсдэл, үе тэнгийн дээрэлхэлт зэрэг олон чухал асуудлыг хөндөн нээлттэй ярилцав.





СДМЭХ “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэйчүүдийн холбоо”-той хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.



СДМЭХ-ны удирдлагууд Хөвсгөл аймагт, ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр ажиллалаа.



“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын эмэгтэй удирдлагуудын “АРИАДНА” клубын бүсгүйчүүдтэй өглөөний уулзалт хийлээ.



“Нэг зорилго, нэг сэтгэл” нөхөрсөг уулзалт, сургалт зохион байгуулагдлаа.



“АЗИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН МАНЛАЙЛЛЫН ХӨТӨЛБӨР”-ийн VI удаагийн сургалт Өмнөговь аймагт зохион байгуулагдаж байна.



“Эмэгтэй улс төрчдийн дуу хоолой” сэдэвт судалгааны тайлантай танилцах уулзалт зохион байгуулагдлаа.



СДМЭХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга У.Өнөрцэцэг “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХОЛБООЧДЫН МЭРГЭЖЛИЙН ЦОГЦОЛБОР” тэмцээний нээлтэд оролцов.



Women in Tech Mongolia-с санаачлан зохион байгуулсан “Women in AI: All About AI” арга хэмжээ амжилттай зохион байгуулагдлаа.



СДМЭХ-ны төлөөлөл Хонг Конг-д зохион байгуулагдсан “Women Power Forum 2026” олон улсын чуулганд үндсэн илтгэгчээр уригдан оролцов.



“МЕНТОР-105” хөтөлбөрийн орон нутаг дахь нээлт амжилттай боллоо.



Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлын хэсгийн уулзалт зохион байгуулагдлаа.



МАН-ын дэргэдэх СДМЭХ-оос хэрэгжүүлж буй “Ментор-105” хөтөлбөрийн ментий нарыг Монгол Ардын Намын дарга, Ерөнхий сайд, Н.Учрал хүлээн авч уулзан, эмэгтэйчүүдийн манлайлал, улс төрийн оролцооны талаар нээлттэй ярилцлаа.



ТӨВИЙН БҮСИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ФОРУМ – 2026 Дархан хотноо амжилттай зохион байгуулагдлаа.



СДМЭХ-ны Архангай аймгийн салбар холбооноос уламжлал болгон зохион байгуулдаг “Гоо сарнай” онцлох эмэгтэй шалгаруулах үйл ажиллагаа амжилттай боллоо.







СДМЭХ-ны Орхон аймгийн салбар холбоо “ОРОН НУТГИЙН МЕНТОР” хөтөлбөрийн нээлтээ хийлээ.

Хөвсгөл аймгийн “ОДОНТОЙ ЭЭЖИЙН ЧУУЛГАН” анх удаа амжилттай зохион байгуулагдлаа.

СДМЭХ-ны Сүхбаатар дүүргийн салбар холбооноос 450 хүүхдэд “ЦАРЦАА НАМЖИЛ” жүжиг үзүүллээ.







“ЭХ ОРОНДОО ДАДЛАГАЖИХ 100×100 ХӨТӨЛБӨР” нээлтээ хийлээ

СДМЭХ-ны Орхон аймаг дахь салбар холбооны дарга Б.Туяагийн санаачилга, зохион байгуулалтаар Алдарт эхийн одон гардуулах ёслолын арга хэмжээний үед, ээжүүд, хүүхдүүдийн тав тух, оролцоог дэмжсэн цогц үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүллээ.

Аймаг, сум, дүүргийн нөхөн сонгуульд мандаас нэр дэвшсэн 8 эмэгтэй нэр дэвшигч ялалт байгууллаа.



СДМЭХ-ны “СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ” Ховд аймагт зохион байгуулагдлаа.



САНГИЙН ДЭД САЙД Б.ХУЛАН

Өдгөө Сангийн дэд сайдын алба хашдаг Б.Хулан дижитал орчин, олон нийтийн харилцаа, залуучуудын оролцооны чиглэлд илүү идэвхтэй ажилладаг байна. Орчин үеийн улс төрийн коммуникаци, хувь хүний имиж бүрдүүлэлт дээр давуу талтай бөгөөд залуу эмэгтэйчүүдийн төлөөлөл болж гарч ирж буй шинэ кадр гэж үнэлэгддэг.



ШИНЭ ҮЕИЙН ЛИДЕРҮҮДИЙ

СОЦИАЛ ДЕМОКРАТ МОНГОЛЫН Э МЭГТЭЙЧҮҮДИЙН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ УИХ-ЫН ГИШҮҮН Д.ҮҮРИЙНТУЯУ



ЕРӨНХИЙ САЙДЫН ЗӨВЛӨХ Б.БУЛГАНЧИМЭГ

Б.Булганчимэг намын дотоод бүтэц, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны чиглэлээр олон жил ажилласан туршлагатай улс төрийн менежментийн төлөөлөл гэж үнэлэгддэг. Ерөнхий сайдын хөрөнгө оруулалт, ногоон хөгжил хариуцсан зөвлөхөөр ажиллаж буй тэрээр улс төрийн хүрээнд илүү “аппаратын тоглогч” төрлийн бүсгүй гэгддэг.



УУЛ УУРХАЙН САЛБАРЫН МАНЛАЙЛАГЧ БҮСГҮЙ Г.ЭРДЭНЭТУЯА

Г.Эрдэнэтуяа нь байгалийн шинжлэх ухаан болон байгаль орчны менежментийн мэргэжлийн боловсролтой бөгөөд үүнийгээ уул уурхайн салбарын практик үйл ажиллагаа, засаглалын өндөр түвшний туршлагатай хослуулсан технократ лидер. Төр, хувийн хэвшил, орон нутгийн иргэдийн дунд “алтан гүүр” болж, эрдэс баялгийн бодлогыг популизмгүйгээр олон нийтэд зөв таниулж чаддаг харилцааны өндөр соёлтой тэрээр эрдэс баялгийн салбарт тасралтгүй 20 гаруй жил ажиллаж буй. МУУҮА-ийн 30 гаруй жилийн түүхэн дэх анхны эмэгтэй Гүйцэтгэх захирлаар амжилттай ажилласан Г.Эрдэнэтуяа тус холбооны дэд Ерөнхийлөгч болсноор уг ажлаа хүлээлгэн өгчээ.

НАМЭХ-оос СДМЭХ болж шинэчлэгдсэн, 15 дэд Ерөнхийлөгчтэй энэ багийг МАН доторх “шинэ үеийн эмэгтэй лидерүүдийн сүлжээ” хэмээн улс төрийн хүрээнд үнэлж буй. Ялангуяа 2024 оны сонгуулиар эмэгтэй улс төрчдийн квот өсөж, УИХ дахь эмэгтэй гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор СДМЭХ-ны нөлөө эрс өссөн. Тухайлбал, СДМЭХ-ны эмэгтэйчүүдийг дотор нь улс төрийн нөлөөтэй лидерүүд, бизнес, менежментээс орж ирсэн технократ эмэгтэйчүүд, залуу үеийн пиар, олон нийт, дижитал нөлөөтэй шинэ кадрууд гэж ангилж болохоор байгаа юм. Тус холбоог УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа удирддаг болсноор дээрх шинэчлэл хийгдсэн байдаг.


Д.Үүрийнтуяа нь МАН дотор бодлогын чиглэлийн эмэгтэй лидер гэж үнэлэгддэг төдийгүй санхүү, эдийн засаг, төсөв, төрийн өмчит үйлдвэрийн чиглэлээр дагнан ажилласан туршлагатай нэгэн гэдгээрээ илүүрхдэг. Тэгэх тусмаа Монгол Улсын төсвийн талаас илүү хувийг бүрдүүлж ирсэн ГОК-ын өсөлт хөгжлийн он жилүүдэд удирдах алба хашиж байсан нь түүний наманарт шигтгээ болон гялалзаж байна. Популист бус, технократ төрлийн улстөрч гэдгээрээ имиж, орон зайгаа тодорхойлох болсон Д.Үүрийнтуяагийн “зурсан”, СДМЭХ-г ирэх жилүүдэд авч явах шинэ үеийн лидер бүсгүйчүүдтэй товч танилцъя.

ЭМЭГТЭЙ
ИН СҮЛЖЭЭ 15



OPERATIONAL MANAGER У.ӨНӨРЦЭЦЭГ

Холбооныхоо operation-al manager-ийн үүрэг гүйцэтгэдэг тэрээр намын дотоод бүтэц, салбар зөвлөлүүдийг зангидан ажилладаг. МАН-ын эмэгтэйчүүдийн бүтэц дээр хүчтэй холбоо сүлбээтэй гэгддэг У.Өнөрцэцэг хууль эрх зүйн боловсрол эзэмшсэн бөгөөд олны өмнө ил гардаг гэхээсээ илүү арын албыг базаж байна.



ЕРӨНХИЙ САЙДЫН ЗӨВЛӨХ Н.ЧИМГҮҮНДАРЬ

Олон улсын дипломат харилцаа, төрийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн МАН-ын шинэ үеийн өндөр боловсролтой Эмэгтэйчүүдийн нэг Н.Чимгүүндарь нь өдгөө Ерөнхий сайд Н.Учралын Аюулгүй байдал, гадаад бодлогын зөвлөхөөр ажиллаж байна. МУИС-ийн ГХСС /гадаад хэл, соёлын сургууль/, Москвагийн Олон улсын харилцааны сургуулийг Олон улсын харилцаа, орон судлал, Францын төрийн удирдлагын сургуулийг Төрийн захиргааны магистр, Сорбонны их сургууль, Парис I Пантеоны сургуулийг олон улсын харилцааны магистраар тус тус төгссөн гээд чамгүй өндөр боловсролтой нэгэн. БНХАУ-д дээд боловсрол эзэмшсэн, бүс нутгийн улс төр, дипломат харилцааны өндөр мэдлэгтэй тул СДМЭХ-ны олон улсын түншлэл, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд том давуу тал болно гэж үзэж буй.



ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДНЫ ЗАХИРАЛ У.ОЮУНЗУЛ

НИТХ-ын төлөөлөгч У.Оюунзул Гэрлэх ёслолын ордны захирал, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн захирал гэж нэр хүндтэй, хариуцлагатай албыг хашсан МАН-ын чадалтай боловсон хүчнүүдийн нэг. Байгаль орчны менежмент, нийгмийн хариуцлага, ногоон байгууламжийн төлөвлөлтийн чиглэлээр мэргэшсэн тэрээр хотын иргэдийн амьдралын чанар, эрүүл мэнд, экологийн боловсролыг практикт хэрэгжүүлж буй лидер бүсгүйчүүдийн тоонд зүй ёсоор тооцогддог. Уг туршлагаараа ч НИТХ-ын түвшинд хотын агаарын бохирдол, хөрсний доройтол, дахин төлөвлөлтийн асуудлуудад мэргэжлийн санал, санаачилга гаргах гол тулгуур нь болж явна.



“EXSELSIOR ENERGY” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.МАНДУХАЙ


Н.Мандухайг ирээдүйд УИХ руу дэвших магадлалтай кадруудын нэг гэж намынхан нь үнэлдэг. Залуу үеийн карьерист улс төрийн төлөөлөл гэдгээрээ олонд танигдаж буй тэрээр Лондонд Regents College төгссөн, олон улсын инженерийн болон эрчим хүчний шийдэл нийлүүлэгч “Exselsior Energy” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг байна. Төв Азийн бүс нутаг болон олон улсын зах зээлд уламжлалт болон сэргээгдэх эрчим хүчний салбарт ажилласан олон жилийн туршлагатай тэрээр холбоондоо бизнес, менежментийн салбараас орж ирсэн технократ эмэгтэйчүүдийн тод төлөөлөл гэгддэг байна.



НИТХ-ЫН ТОД ОД Б.АНУ-УЖИН
СДМЭХ-ны удирдлагын баг дахь шинэ үеийн залуучуудын тод төлөөлөл, НИТХ-ын төлөөлөгч Б.Ану-Ужин. Сошиал медиа болон цахим орчинд өөрийн гэсэн орон зай, имижийг үүсгэж чадсан нөлөө бүхий хотын төлөөлөгч. Тэрээр хуурай онол, ерөнхий улс төр ярихаас илүү хотын хамгийн хүнд салбар болох авто зам, нийтийн тээврийн сорилтуудыг практик амьдралд хэрхэн хослуулах чиглэлд карьер асуудлыг хөрсөн дээр нь харж, шийдэл гаргадгаараа олонд танигдаж байв.

САЙДЫН ЗӨВЛӨХ АСАН Б.ЭНХ-УНДРАМ
Бусад дэд ерөнхийлөгчдөө бодвол олон нийтэд танигдсан фигургүй. Б.Энх-Ундрам өмнө нь УИХ-ын Тамгын газрын Ажлын албаны зөвлөх, Ерөнхий сайд асан Г.Занданшатарын зөвлөхөөр ажиллаж байжээ. Сайдын зөвлөх хийж байсан тэрээр чухамдаа төрийн бодлого боловсруулах, улс төрийн стратеги чиглэл, залуу үеийн намын менежмент талдаа мэргэшсэн нэгэн аж.






“СИ ЭЙЧ БИ ЖИ КОНСТРАКШН” КОМПАНИЙН ДЭД ЗАХИРАЛ Н.БУЛГАНТУУЛ
СДМЭХ-ны Хангайн бүс хариуцсан дэд ерөнхийлөгч Н.Булгантуул бизнесийн удирдлага, төслийн менежментээр мэргэшсэн нэгэн. Тэрээр МУИС-ийг санхүүч эдийн засагч, эрх зүйч мэргэжлээр тус тус төгссөн улмаар Удирдлагын академид төрийн захиргааны менежмент болон төрийн удирдлагаар докторантын зэрэг хамгаалжээ. Өдгөө “Си Эйч Би Жи констракшн” ХХК-ийн дэд захирлаар ажиллаж байна.



АУДИТОР Н.СҮНЖИДМАА
Хууль эрх зүй, төрийн захиргааны чиглэлээр ажилласан туршлагатай гэж үнэлэгддэг Н.Сүнжидмаа нь эрх зүйч, төрийн захиргааны удирдлагын менежер мэргэжилтэй. МУИС-ийг эрх зүйч, хууль зүйн магистр, Удирдлагын академийг төрийн удирдлагын менежерээр төгсжээ. Тэрээр өдгөө дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар ТӨҮГ-т дотоод аудитораар ажилладаг байна.




“УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МЕНЕЖМЕНТ УЦК” КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ГАНГАМӨРӨН
Г.Гангамөрөн сэтгүүл зүй, хүний эрхийн чиглэлээс улс төрд хөл тавьсан, нийслэлийн бодлого болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр мэргэшсэн нэгэн. НИТХ-ын төлөөлөгч асан тэрээр МАН дотор хотын фракц болон залуу үеийн лидерүүдийн дэмжлэгийг хүлээсэн гэгддэг. Мөн СДМЭХ-ны дэд Ерөнхийлөгчийн хувиар эмэгтэйчүүдийн манлайллын сургалт, орон нутаг дахь салбар зөвлөлүүдийн идэвхжүүлэлтийг хариуцан ажилладаг байна.




ХӨДӨЛМӨРИЙН БААТАР Ч.ГАНЦЭЦЭГ

Хөдөлмөрийн баатар, Монголын ноос, ноолуурын салбарын топ тоглогч “Ханбогд кашимер” ХХК-ийн захирал Ч.Ганцэцэг СДМЭХ-ны дэд Ерөнхийлөгчийн хувиар өөрийн арвин туршлага, мэдлэгээ нийгэм, улс төрийн салбарт зориулж буй шийдвэр гаргах түвшний хамгийн нөлөө бүхий “ахмад үеийн” лидер гэгддэг. Монголын ноолуурын салбарыг дэлхийн брэнд болгоход жинтэй хувь нэмэр оруулж буй тэрээр үндэсний томоохон үйлдвэрлэгч “Ханбогд кашимер” ХХК-ийг амжилттай удирдаж, олон зуун ажлын байр бий болгон, нэмүү өртөг шингэсэн экспортыг хөгжүүлсэн гавьяаг нь үнэлж 2024 онд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цолоор шагнасан билээ.




СХД-ИЙН СДМЭХ-НЫ ТЭРГҮҮН Э.ХУЛАН

МАН-ын нөлөө бүхий ахмад улс төрчдийн нэг М.Энхболдын охин Э.Хулан хотын улс төрийн талбараас өсөж буй шинэ үеийн эмэгтэй улс төрчдийн нэг. НИТХ болон хотын бодлогын хүрээнд ажилласан туршлагатай Э.Хулан нийслэлийн хөгжлийн асуудал, залуучуудын оролцоо, дижитал орчны коммуникаци дээр илүү танигдсан. Их Британийн Грийнвичийн их сургуулийг хүний нөөцийн менежер, МУИС-ийг эрх зүйч мэргэжлээр төгссөн гэвч боловсролын хувьд гадаад хэл, менежмент, олон нийттэй харилцах ур чадвартай, улс төрд мерит зарчмаар бэлтгэгдсэн нэгэн юм.



IT PARK-ЫН АНХНЫ ЭМЭГТЭЙ ЗАХИРАЛ Ж.ЗОЛЗАЯА

Бизнесийн менежментийн магистр зэрэгтэй бөгөөд гарааны бизнес, инновац, технологийн салбарт олон жил ажилласан туршлагатай Ж.Золзаяа. “Стартап Маркетинг Спэйс” ХХК-ийн үүсгэн байгуулагч, “Seedstars” олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгч, Монголын Үндэсний Маркетингийн Холбооны үүсгэн байгуулагч, УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооны зөвлөхөөр ажиллаж байсан гээд туршлага ихтэй бүсгүй. Тэрээр 2023 онд Мэдээлэл технологийн үндэсний паркийн анхны эмэгтэй захирлаар томилогдсон нь технологийн салбар дахь эмэгтэй манлайллын шинэ өнгө төрх болсон гэж үздэг.



“ДИЙПЛЭЙК” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Л.БОЛОРМАА

НИТХ-ын төлөөлөгч Л.Болормаа аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлж буй “Дийплэйк” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар давхар ажилладаг. Тэрээр намын дотоод бүтэц, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих улс төрийн үйл хэргээс гадна дотоодын аялал жуулчлалын менежментийг сайжруулах, төрийн худалдан авах ажиллагаа болон төсөл хөтөлбөрүүдэд компанийн зүгээс хариуцлагатай оролцох замаар бизнесийн салбарт өөрийн гэсэн байр суурийг тодорхойлж байна.

Эх сурвалж:
Гранд сэтгүүл №147, 2026 оны 06 сар.



ТАЛАРХАЛ

Энэхүү тайлангаар 2026 оны хаврын чуулганы хугацаанд хууль тогтоох болон бодлого хэрэгжүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг иргэд, сонгогчид, олон нийтэд ил тод танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүний хувьд хууль тогтоох үйл ажиллагаа, бодлогын санаачилга, иргэдийн санал хүсэлтийг шийдвэр гаргах түвшинд хүргэхийн зэрэгцээ Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбооны Ерөнхийлөгчийн хувьд эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн хөгжлийн бодлогыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд нь бодлогын уялдаа, салбар хоорондын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжлээ.

Дээрх ажлуудыг хэрэгжүүлэх явцад бодлогын уялдаа, салбар хоорондын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоо чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд эдгээрийн үр дүнд нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тойргийн иргэдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодит алхмууд хийгдсэн гэж үзэж байна.

Цаашид иргэдийн амьдралд бодитоор мэдрэгдэх өөрчлөлтийг бий болгох, орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтыг илүү оновчтой, үр ашигтай болгох, төрийн бодлогын чанар, хууль тогтоомжийн уялдааг сайжруулах чиглэлд тууштай ажиллах болно. Мөн СДМЭХ-ны Ерөнхийлөгчийн хувьд эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, шинэ үеийн манлайлагчдыг бэлтгэх, нийгмийн эерэг өөрчлөлтийг дэмжих бодлого, хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, иргэдийн дуу хоолой, санал санаачилгыг бодлого боловсруулах түвшинд илүү өргөн хүрээнд тусган, ил тод, хариуцлагатай, үр дүнд суурилсан үйл ажиллагааг эрхэм зорилгоо болгон ажиллахыг зорино.

Энэхүү ажлыг хэрэгжүүлэхэд үнэтэй санал, дэмжлэг үзүүлж, идэвхтэй хамтран ажилласан Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, Булган, Орхон, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нар, бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд, тойргийн иргэд, сонгогчид болон хамтран ажиллагч бүх талд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Мөн СДМЭХ-ны Ерөнхийлөгчийн хувьд холбооны бодлого, зорилтыг хэрэгжүүлэх үйлсэд хамтран ажиллаж буй СДМЭХ-ны ажлын алба, удирдлагын баг, салбар холбоодын удирдлага, нийт гишүүд, дэмжигчиддээ чин сэтгэлийн талархал илэрхийлж, хамтын оролцоо, итгэл дэмжлэг нь эмэгтэйчүүдийн манлайлал, нийгмийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны чухал суурь болж байгааг онцлон тэмдэглэж байна.

Төрийн шийдвэр бүр ард иргэдийн

амьдралд хүрч байх учиртай



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

